**Монгол Улсын Засгийн Газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхайн сайдын эрхлэх асуудлаар хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтэд 2016 оны хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан.**

2016 оны 07 дугаар сарын 05

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхайн сайдын эрхлэх асуудлаар 54 зорилтын 127 арга хэмжээг хяналтанд авснаас 18 арга хэмжээг дангаар, 30 арга хэмжээг толгойлон, 79 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба эдгээрийн биелэлтэд 2016 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Уул уурхайн яамны 2016 оны хагас жилд хэрэгжүүлсэн нийт 127 арга хэмжээнээс дангаар хэрэгжүүлсэн 18 арга хэмжээний биелэлт 91,7%, толгойлон хэрэгжүүлсэн 30 арга хэмжээний биелэлт 94,0%, хамтран хэрэгжүүлсэн 79 арга хэмжээний биелэлт 88,7%, нийт арга хэмжээний биелэлт 90,4%-ийн биелэлттэй дүгнэгдсэн.

<u>Биелэлтэд үнэлгээ хийгээгүй</u>:

Толгойлон хэрэгжүүлэгч байгууллагаас санал ирүүлээгүй, салбарын хяналтыг яаманд хамааруулах асуудал шийдэгдээгүй тул доорх 4 арга хэмжээний биелэлтэд үнгэлгээ өгөөгүй болно.

*25.2. БНХАУ, Канад Улс болон Бүгд Найрамдах Сингапур Улстай байгуулсан давхар татварын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэлэлцэн тохирогч улсуудтай хэлэлцээр хийж, саналаа холбогдох төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.*

*106.2. Үйлдвэрүүдийг уялдаа холбоотойгоор, цогцоор нь байгуулах ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.*

*235.1. Уул уурхай, газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд биологийн олон янз байдлыг боломжит өөр газарт дүйцүүлэн хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хэрэгжүүлнэ.*

*235.2. Байгалийн нөөц ашиглах болон үйлдвэрлэлээс үзүүлэх хуримтлагдах нөлөөлөл, байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг бүс нутаг, сав газрын хэмжээнд хийж, хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.*

Дүгнэлт.

Уул уурхайн яам нь Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан, Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхайн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг хангалттай сайн биелүүлж ажилласан байна.

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан нэгтгэлийг хавсаргав.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Д.Жавхланболд

Тайлан бичсэн:
ХШҮДАГ-ын
Ахлах мэргэжилтэн Б.Баяржаргал

2016 оны 07 сарын 5 өдөр

**УУЛ УУРХАЙН САЙДЫн ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ХУУЛЬ, ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ**

**/2016 оны эхний хагас жилийн байдлаар/**

**2016/07/04**

| № | Эрх зүйн актын нэр, огноо, дугаар: Заалт | Агуулга | Хариуцах нэгж | Биелэлт | Оноо | Хүчингүй болсон буюу хяналтаас хассан тухай тэмдэглэл/ өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт |
|---|---|---|---|---|---|---|
| **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ** | | | | | | |
| 1 | **2015-12-18. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай** | 7.5.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. | ХШҮДАГ | УУЯ нь Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичиг, ЗГ-ын Үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтэд 2015 оны жилийн эцсийн байдлаар х/ш/ү хийж тайланг тогтоосон хугацаанд нь ЗГХЭГ, СЯ-нд тус тус хүргүүлж ажилласан. ХБТХуулийн 7.5. дахь заалтын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хугацаа болоогүй. | 70 | |
| 2 | **2015-09-30. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/** | 12.5.Энэ хуулийн 12.1.7-д заасан экспортод гаргасан ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал, кодыг Засгийн газар тогтооно. | СБТГ | Сангийн яамнаас боловсруулж ирүүлсэн экспортод гаргасан ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал, кодыг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох санал өгч хамтран ажилласан. “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 502 дугаар тогтоолоор ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний жагсаалтыг баталсан. | 100 | |
| 3 | **Ашигт малтмалын** | 472.2.Энэ хуулийн 472.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт | БХЗГ | Стратегийн ач холбогдол бүхий Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох Засгийн | 50 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай** | малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална. | | газрын тогтоолын төсөл боловсруулж байна. Биелэлт 70% | | |
| 4 | **2015-10. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** | “12.10.Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, цацрагтай ажиллагч нь ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд ажлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг Цөмийн энергийн комисс батална.” | СБТГ | Уг хуулиар цөмийн болон цацрагийн хяналтын байцаагч, цацрагтай ажиллагчийн ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэх, ажлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журамд өөрчлөлт оруулах асуудлаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар санал боловсруулж, түүнийг Цөмийн энергийн комисс батлахаар заасан. Үнэлгээгүй | /-/ | |
| 5 | **2/17.5. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** | 1/16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: “2.Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-3-т заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний 2 тэжээгч нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан 2 даатгуулагчийн авч байсан хөдөлмөрийн хөлсний нийлбэрээс энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хувь хэмжээгээр бодож тогтооно.” 2/22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг: “4.Даатгуулагчийн 1995 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан ажил, мэргэжлийн жишиг цалинд үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлж болно.” 3/28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт: | ТЗУГ | Уул уурхайн яам байгуулагдсанаас хойш Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасны дагуу 3 албан хаагч тэтгэвэрт гарсан. Уг албан хаагчдад ТАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2-д заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. Энэ хуулийн заалт тус яаманд хамааралгүй болно. | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | “2/авч байгаа тэтгэврийг нь тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлсний хэмжээг дүйцүүлэн тооцох итгэлцүүрийг Засгийн газраас шинэчлэн тогтоосонтой уялдуулан хөдөлмөрийн хөлсний хэмжээ өөрчлөгдөх үндэслэлтэй болсон нь тогтоогдож тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан бол зөвхөн нэг удаа;” | | | | |
| 6 | **2014-07-01 Газрын тосны тухай /Шинэчил-сэн найруулга/** | 7.1.4 Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах; газрын тосны бүртгэл, тооцоо; газрын тосны салбарыг хөгжүүлэх сан; уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг батлах; | ТБЗГ | 1. Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах **ж**урмын төслийг ГТГ-тай хамтран боловсруулж, дотоодын зөвлөхийг ажиллуулж, төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Боловсруулсан төсөл дээр АНУ-ын худалдааны яамны зөвлөхүүдээс саналыг авч төсөлд тусгасан. Мөн АНУ-ын худалдааны яам, Монгол дахь элчин сайдын яамтай хамтран 3 хоногийн семинар зохион байгуулсан. Семинараас өгсөн зөвлөмжийн дагуу төслийг дахин боловсруулсан. Журамтай холбогдуулан 2 удаа АНУ-ын хуулийн болон санхүүгийн зөвлөхүүдтэй видео конференц зохион байгуулсан бөгөөд Уул уурхайн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.<br>Биелэлт 90%<br>2. Газрын тосны бүртгэл, тооцоожурмын төслийн эхний хувилбарыг ГТГ-тай хамтран боловсруулсан. Боловсруулсан төсөл дээр АНУ-ын худалдааны яамны зөвлөхүүдээс саналыг авч төсөлд тусгасан. Мөн АНУ-ын худалдааны яам, Монгол дахь элчин сайдын яамтай хамтран 3 хоногийн семинар зохион байгуулсан. Семинараас өгсөн зөвлөмжийн дагуу төслийг дахин боловсруулсан. Журмын төсөлд зөвлөмж | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | авахаар гадаадын холбогдох төслүүдэд албан тоотоор санал хүргүүлээд байна.<br>Биелэлт 80%<br>3. Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыгболовсруулж, мэргэжлийн холбоод, шинжлэх ухааны байгууллагуудаас санал авч тусган, Уул уурхайн сайдын зөвлөлийн 2015 оны 5-р сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Журмын төсөлд яамдаас санал авч холбогдох саналыг тусган Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 295 дугаар тогтоолоор батлуулсан. Уг журмыг Уул уурхайн яамны цахим хуудсанд www.mm.gov.mnбайршуулсан.<br>Биелэлт 100%<br>4. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2014.01.23-ны өдрийн хуулиар "Газрын тосны салбарыг хөгжүүлэх сан"-г хассан. Иймд тус журмыг боловсруулах шаардлагагүй болсон.<br>Биелэлт 100% | | |
| 7 | | 8.1.3 Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах; | | Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлагын төслийг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч хянан тусгасан. Журмын төслийг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгож, ТЗУГ-т дотоод албан бичгээр хүргүүлсэн.<br>Биелэлт 90 хувь<br>1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлагыг эцэслэн боловсруулж, мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч тусган 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Уул уурхайн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэнУул уурхайн | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сайдын 2015.03.10-ны 49 тоот тушаалаар батлуулсан. Мөн Хууль зүйн яаманд журмын дагуу бүртгүүлж, Уул уурхайн яамны цахим хуудсанд www.mm.gov.mnбайршуулсан.<br>Биелэлт 100 хувь<br>2. Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлагыг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч төсөлд тусган 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн сайдын 2015.09.04-ны өдрийн 197 дугаар тушаалаар батлуулсан.<br>Биелэлт 100 хувь<br>3. Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журмыг боловсруулж, Уул уурхайн сайдын 2014 оны 202 тоот тушаалаар батлуулан Хууль зүйн яаманд 2014.10.15-ны өдөр нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын жагсаалтад бүртгүүлсэн.<br>Биелэлт 100 хувь<br>4. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журмыг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн Уул уурхайн сайдын2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн сайдын 2015.09.04-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлуулсан.<br>Биелэлт 100 хувь<br>5. Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмын төслийг боловсруулж, Уул уурхайн сайдын 2015 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 53 дугаар тушаалаар батлуулсан. Угжурмыг ХЗЯ-аар бүртгүүлж, УУЯ-ны | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | www.mm.gov.mn цахим хуудсанд байршуулсан.<br>Биелэлт 100 хувь | | |
| 8 | | 8.1.8газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах; | ТБЗГ | “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам”-ыг боловсруулах БОНХАЖ, Уул уурхайн сайдын 2015.03.24-ний өдрийн 62/А-131 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг ажиллаж, төслийг боловсруулан БОНХАЖ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанаар 2015.11.11-ний өдөр хэлэлцүүлсэн. Уул уурхайн сайдын зөвлөлийн хуралдаанаар нийт 2 удаа хэлэлцүүлэн УУС-ын тушаалаар батлуулж, журмын дагуу Хууль зүйн яаманд бүртгүүлэхээр холбогдох материалыг бүрдүүлж хүргүүлсэн.<br>Биелэлт 100 хувь | 100 | |
| 9 | | 8.1.9газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах; | ТБЗГ | “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-г боловсруулж, холбогдох байгууллага, аж ахуй нэгжүүдээс саналыг авсан. Дүрмийн төслийг Уул уурхайн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр яамны удирдлагуудад журмыг батлах тухай тушаалын төслийг хамт танилцуулан санал авч тусгасан. Журмыг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган хүлээж байна.<br>Биелэлт 90 хувь | 90 | |
| 10 | **2013_03. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай** | 10.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг геологи, уул уурхайн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран батална. | УУБХ | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмын төслийг боловсруулж байна. Мөн “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийн хүрээнд холбогдох байгууллага, мэргэжлийн холбоодтой санал солилцож, тэдгээрийн саналыг тусган нэгтгэх ажлыг зохион байгуулж байна. | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **(шинэчил-сэн найруулга)** | | | Биелэлт-70% | | |
| 11 | **2009_03. Хүний хөгжил сангийн тухай** | 13.2. Энэ хуулийн 13.1-д заасан сонгон шалгаруулалтын журам болонменежментийн гэрээг Засгийн газар батална./13.1.Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээдийн чиг үүргийг дараахь шаардлагыг хангасан олон улсын санхүүгийн байгууллагад сонгон шалгаруулалтын үндсэн дээр менежментийн гэрээгээр хэсэгчлэн шилжүүлж болно: 8.2.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлнэ./ | СБТГ | Уг асуудлыг “Эрдэнэс Монгол” ХХК хэрэгжүүлж байна. “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн хувьд Оросын Холбооны Улс-Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлж байна.<br>/Үнэлгээгүй/ | /-/ | |
| 12 | **2009_02. Цөмийн энергийн тухай** | 28.10. Энэ хуулийн 28.9-дзаасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдлийг харгалзан цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. /28.9: Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулна/. | БХЗГ | Уул уурхайн сайдаас Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9, 28,10 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор танилцуулга, захирамжийн төслийг ерөнхий сайдад танилцуулахаар бэлэн болоод байна.<br>Биелэлт 90% | 90 | |
| 13 | | 33.4. Цөмийн материалыг бүртгэх, хянах журмыг Засгийн газар батална. | БХЗГ | 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн ЦЭТХхуулийн нэмэлт өөрчлөлт, 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын 72 дугаар тогтоолд зааснаар ЦЭК-ын эрх үүргийн | /-/ | |
| 14 | | 39.3. Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журмыг Засгийн | БХЗГ | | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | газар батална. | | талаар: | | |
| 15 | | 42.4. Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрмийг Засгийн газар батална. | БХЗГ | - “цөмийн материалын тооллого, алдагдал, хорогдол, шилжилт хөдөлгөөн хийх журмыг батлах, | /-/ | |
| 16 | **2015-10. Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** | 6.Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах, цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар нөхөн сэргээх, цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээнд хамаарахгүй. 7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.” | БХЗГ | - “цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журмыг батлах”,<br>- “цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, цацрагийн ослын хор уршгийг арилгах талаар яаралтай авах арга хэмжээний талаарх саналыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх” гэж заасан байдаг.<br>Иймд эрхлэх чиг үүргийн дагуу ЦЭК-ын ажлын алба эдгээр асуудлыг хариуцан ажиллаж байна.<br>ЦЭК-ын ажлын албанаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд эдгээр дүрэм журмуудыг 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө оруулж ажиллахаар төлөвлөсөн байна.<br>Биелэлт 100% | /-/ | |
| **УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ** | | | | | | |
| 1 | 19-/16.04/ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- | 2/Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай | | Биелэлт гаргах хугацаа болоогүй.<br>үнэлгээгүй | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2030 батлах тухай | тохиолдолд шинэчлэн боловсруулах; | | | | |
| 2 | 108-2015-12-30. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | 3/эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусад салбарын бүх шатны төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдуулан ажлын цагийг уян хатан тогтоож үр дүнг цагаар тооцох, сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх зэргээр бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цалингийн зардлын 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлт бий болгох; | СБТГ ЭЗХОХ | Төрийн үйлчилгээ улсын үйлдвэрийн газартай "Төсөвт байгууллагын зарим ажил, үйлчилгээг гүйцэтгэх гэрээ"-г байгуулан батлагдсан төсвийн хүрээнд гэрээгээр гүйцэтгүүлэхээр зөвшөөрөгдсөн ажил, үйлчилгээ, уг ажил үйлчилгээг гүйцэтгэх даалгаврыг өгч, төлбөрийг гүйцэтгэлээр тооцож, төсвийн жилд хийлгэн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын хэмжээнд цалингийн зардлын 1,0 хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлтийг бий болгосон.<br>Биелэлт-100% | 100 | |
| 3 | 69-2015-09. Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | 1/2014 оны төсвийн орлого, төсвийн тэнцэл, Засгийн газрын өр нь Төсвийн тогтвортой байдлын тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуулиудыг зөрчсөнд дүгнэлт хийж, цаашид хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах; | СБТГ ЭЗХОХ | Уул уурхайн сайдын багцын 2015 оны батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа төлөвлөн санхүүжүүлж, батлагдсан төсвийн хязгаарт багтаан 2016 оны төсвийг төлөвлөн батлуулж, Сангийн сайдын баталсан сар улирлын хуваарийн дагуу санхүүжилтийг авч. Хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, хугацаанд нь тайлагнан ажиллаж байна.<br>Биелэлт 100% | 100 | |
| 4 | 52-2015-09. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг | 5. 2/Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад тавих дотоодын байнгын хяналтыг сайжруулах, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх Засгийн газрын байгууллагын чадавхыг сайжруулах арга хэмжээ авах; | ХШҮДАГ | Эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Уул уурхайн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 6 арга хэмжээг хяналтанд авч хэрэгжилтэд 2015 оны хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зохих шийдвэрийг гаргуулж холбогдох журмын дагуу хугацаанд нь СЯ-нд хүргүүлж ажилласан. 2015 оны үндсэн чиглэлийн биелэлт жилийн | 90 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | батлах тухай | | | эцсийн байдлаар 81,7%-ийн биелэлттэй. Биелэлт-90% | | |
| 5 | **2**015_41. Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай | 1. Хавсралтын биелэлт бичих | БҮХ ГАЗ-РУУД | 1. Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар Алтны олборлолтыг нэмэгдүүлэх тогтоолын төслийг хэлэлцүүлж батлуулсан.<br>Уг ЗГ-ын 94-р тогтоолд заасны дагуу зээл авах хүсэлтээ ирүүлсэн, Уулын ажлын төлөвлөгөө батлагдсан алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг Монголбанкинд хүргүүлсэн. зээлийн санхүүжилт олгох схемийг гаргасан ба ЗГ-ын 2015 онд 311 дүгээр тогтоолоор уг асуудал шийдэгдсэн.<br><br>2. “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг УИХ-р хэлэлцүүлэн 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр батлагдаж, 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.<br>Энэ хуулийн 3 дугаар зүйлд “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг Засгийн газар батална” гэж заасны дагуу жрам гэрээний загварыг ЗГ-ын 2015-03.30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлуулсан. мөн Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу ЗГ-ын 135 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан.<br>Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд өмнө үйл ажиллагаа эхэлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчид өргөдөл гаргавал уг хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т заасны дагуу гэрээ байгуулах ажил явагдаж байна. БОНХАЖЯ-аас хилийг заагийг тогтоох тухай ЗГ-ын 2011 оны | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 174, 2012 оны 194 дүгээр тогтоолуудад 2015 ЗГ-ын 289, 302 дугаар тогтоолуудаар өөрчлөлт оруулж хуульд нийцүүлсэн.<br><br>3. Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж 103 дугаар тогтоол гаргуулсан.<br>БНХАУ-ын Шаньси мужийн Лихэнг гангийн үйлдвэр, Монголын Төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбоо Монгол Улсаас жилд 20 сая хүртэлх тонн төмрийн хүдэр, баяжмал нийлүүлэх санамж бичиг байгуулсан.<br>Санамж бичгийн дагуу төмрийн хүдрийн уурхай эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй төмрийн хүдрийг хүдрийн экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж 2015 оны төлөвлөгөөт зорилтыг давуулан биелүүлсэн. 2015 онд 4.8 сая тонн төмрийн хүдэр экспортлохоор төлөвлөсөнөөс 12 дугаар сарын байдлаар Төмрийн хүдрийн экспорт 5.1 сая тн, 2016 онд 5.0 сая тонн төмрийн хүдэр экспортлохоор төлөвлөсөнөөс 2016 оны эхний хагас жилийн байдлаар ... тн төмрийн хүдэр экспортлоод байна.<br><br>4. Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших MV-000011 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эрдэнэтийн Овооны зэс-молибденийн ордын төвийн хэсгийг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг ШУТИС-ийн харъяа “Уул уурхайн хүрээлэн”, ОХУ-ын Москва дахь “Гипроцветмет” хүрээлэнгийн зураг төсөл, эрдэм шинжилгээний инженерүүд хамтран боловсруулсан.<br>Уул уурхайн сайдын 2014 оны 106 дугаар тушаалаар шинжээчийн хэсгийг томилж уг техник, эдийн засгийн үндэслэлд шинжээчийн дүгнэлтийг гаргасан. Улмаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар 2014 оны 07 дугаар сарын 09-ны өдөр хэлэлцүүлж ТЭЗҮ-г хүлээн авсан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тус ордын төвийн хэсгийг ил аргаар ашиглах бэлтгэл ажлыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК бэлтгэлажлыг ханган ажиллаж байна.<br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг 25%-иар нэмэгдүүлж жилд 26 сая тонн хүдэр боловсруулдаг байсныг 32 сая тоннд хүргэж 2015 оны 6-р сарын 20-ны өдөр албан ёсоор нээлт хийжээ.<br>5. Уг асуудлыг Аж үйлдвэрийн яам хариуцан ажиллаж байна. УИХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолоор тус ордод төр хувь эзэмших шаардлагагүй гэсэн шийдвэр гаргасан бөгөөд Монгол Улсын Засгийн газар болон “Монголын алт” ХХК, “Эрдэнэс Цагаансуварга” ХХК-ийн хооронд 2015 оны 11 сард тус ордыг түшиглэн байгуулах Баяжуулах үйлдвэрийн Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан. /ХБНГУ-аас “Монголын алт” ХХК-д олгох зээлийн санхүүжилтэд Монгол Улсын Засгийн газраас баталгаа гаргасан/ | | |
| 6 | | 2. “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг хамтран боловсруулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/-нд үүрэг болгосугай. | БҮХ ГАЗ-РУУД | УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гаргах арга хэмжээний тухай хөтөлбөр”-ийн 7.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Алт худалдан авах урьдчилсан санхүүжилтийн тогтолцооны тухай” Засгийн газрын 311 дүгээр тогтоол 2015 оны 7 сарын 27-ны өдөр батлагдсан.<br>Энэхүү тогтоолын зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах, бодит салбарын хөгжлийг дэмжих, гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлэхээр алт худалдан авах урьдчилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн эргэлтийн хөрөнгөнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 256,0 тэрбум хүртэлх төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банкуудаар дамжуулан он дуустал олгоно.<br>Алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн хүсэлт, өрийн баталгааны санд төлсөн шимтгэлийг үндэслэн нийт санхүүжилтийн эх үүсвэрийн | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | | | | үндсэн төлбөрийн 50 хүртэл хувьд Засгийн газрын өрийн баталгаа гаргана.<br>Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Уул уурхайн сайд нарын хамтарсан тушаал гарсан бөгөөд Алт үйлдвэрлэгчдийн холбооноос нэр бүхий 46 аж ахуйн нэгжийн хүсэлтийг уламжлан ирүүлсэн. Дээрх хүсэлтүүдийг 2015 оны батлагдсан уулын ажлын төлөвлөгөөтэй харьцуулан судалгаа хийж, Монголбанкинд уламжилсан. Биелэлт 100% | | |
| | | 3.“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож, хөтөлбөрт заасан хугацаанд хэрэгжээгүй заалт бүрийг хариуцах албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэж, хөтөлбөрийн биелэлтийг хагас жил тутамд Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/-нд үүрэг болгосугай. | БҮХ ГАЗ-РУУД | УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гаргах арга хэмжээний тухай хөтөлбөр”-ийн 7.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Алт худалдан авах урьдчилсан санхүүжилтийн тогтолцооны тухай” Засгийн газрын 311 дүгээр тогтоол 2015 оны 7 сарын 27-ны өдөр батлагдсан.<br>Энэхүү тогтоолын зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах, бодит салбарын хөгжлийг дэмжих, гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлэхээр алт худалдан авах урьдчилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн эргэлтийн хөрөнгөнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 256,0 тэрбум хүртэлх төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банкуудаар дамжуулан он дуустал олгоно.<br>Алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн хүсэлт, өрийн баталгааны санд төлсөн шимтгэлийг үндэслэн нийт санхүүжилтийн эх үүсвэрийн үндсэн төлбөрийн 50 хүртэл хувьд Засгийн газрын өрийн баталгаа гаргана.<br>Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Уул уурхайн сайд нарын хамтарсан тушаал гарсан бөгөөд Алт үйлдвэрлэгчдийн холбооноос нэр бүхий 46 аж ахуйн нэгжийн хүсэлтийг уламжлан ирүүлсэн. Дээрх хүсэлтүүдийг 2015 оны батлагдсан уулын ажлын төлөвлөгөөтэй харьцуулан судалгаа хийж, Монголбанкинд уламжилсан. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой тус яамны хариуцах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг нэгтгэж, Сангийн яаманд /2015.03.10-ны 3/567 тоотоор/ хүргүүлсэн.<br>Биелэлт 100% | | |
| 8 | 2015_36. Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай | 2/Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр худалдах, худалдан авах замаар хөрөнгийн зах зээлд оролцох, санхүүжилт босгох зорилтыг хэрэгжүүлэх, олон улсын хөрөнгийн зах зээлд Монгол Улсын нэр хүндийг өсгөх боломжийг судалж хэрэгжүүлэх; | СБТГ | Стратегийн ач холбогдол бүхий “Багануур” ХХК-ийн 25 хувь, “Шивээ-Овоо” ХК-ийн 10 хувийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр худалдаж байна. Мөн хувьцаа худалдан авах замаар хөрөнгийн зах зээлд оролцох, санхүүжилт босгох зорилтыг хэрэгжүүлэх, олон улсын хөрөнгийн зах зээлд гаргах асуудлыг судалж байна. Стратегийн ордуудын төрийн эзэмшлийн хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-д төвлөрүүлэх замаар дээрх зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>Биелэлт-70% | 70 | |
| 9 | | 3/гол нэр төрлийн эрдэс баялгийн үйлдвэрлэлийн биет хэмжээг тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл болон уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн санал, тухайн салбарын урт, дунд хугацааны үйлдвэрлэлийн төлөвлөгөөний төсөөлөлд үндэслэн тооцоолдог аргачлалыг боловсруулж мөрдүүлэх, орлогын бүрдүүлэлтийг сайжруулах чиглэлээр нөөц бололцоогоо бүрэн дайчлах; | СБТГ | 2016 оны эхний 5 сарын байдлаар нүүрс 9.7 сая тонн, алт 4.4 тн, газрын тос 500.7 мянган тонныг тус тус олборлоод байна. Хайлуур жоншны баяжмал 72.0 мянган тонн, зэсийн хүдрийн баяжмал 619.7 мянган тонн, төмрийн хүдрийн баяжмал 1.5 сая тонн, цайрын баяжмал 36.5 мянган тонныг тус тус үйлдвэрлэсэн байна. 2016 оны эхний 5 сарын байдлаар 697.7 мянган тонн зэсийн баяжмал, төмрийн хүдрийн тухайд 1.9 сая тонн, алт 5.2 тн, нүүрс 7.2 сая тонн, газрын тос 484.7 мянган тонныг тус тус экспортлосон ба Эрдэс баялгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс 2016 оны эхний 5 сарын байдлаар 302.9 тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлсэн ба газрын тосны газраас 45.0 тэрбум төгрөг, Ашигт малтмалын газраас 15.2 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. СЯ, УУЯ, Гааль, Татварын | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ерөнхий газар болон АМГ-тай хамтран гол нэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг эрэлт, нийлүүлтэд тулгуурлан үндэслэлтэй боловсруулах чиглэлээр ажиллаж байна.<br>Биелэлт 70% | | |
| 10 | 2015_11. “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | 2.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хил хязгаарыг нарийвчлан тогтоож, ордыг иж бүрнээр ашиглах бодлого баримталж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай. | СБТГ | Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын хил хязгаарыг нарийвчлан тогтоож, ордыг иж бүрнээр ашиглах бодлогыг баримтлан ажиллаж байна.<br>Биелэлт-90% | 90 | |
| 11 | 02_2014_18. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай | 2."Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай: 1/"Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын зарчим, зорилтод нийцүүлэн эрдэс баялгийн салбарын холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулан хэрэгжүүлэх; 2/"Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-д тусгасан зорилт, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, төрийн мөнгөний бодлого, дунд, урт хугацааны төлөвлөлтөд | СБТГ | 1. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын зарчим, зорилтод нийцүүлэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн УИХ-ын чуулганаар батлуулсан.<br>2. "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-д тусгасан зорилт, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл болон урт, дунд хугацааны хөтөлбөрт тухай бүр тусган ажиллаж байна.<br>Биелэлт-100% | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тусгуулан хэрэгжүүлэх. | | | | |
| 12 | 2013_41. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | 6. Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдийн хувьцааг Хөрөнгийн биржээр арилжаалах ажлыг 2013 онд багтаан зохион байгуулах. | СБТГ | "Багануур" ХК-ийн 25 хувь, "Шивээ-Овоо" ХК-ийн хувьцааны 10 хувийг Монголын Хөрөнгийн бирж дээр арилжаалж байна. Стратегийн ордын төрийн эзэмшлийн хувийг "Эрдэнэс МГЛ" ХХК-д эзэмшүүлэх ажил үе шаттай явагдаж байна.<br>Биелэлт 90% | 90 | |
| 13 | 02_2009_55. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**й** | 1.2. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийн дотор үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашигт малтмалын тухай болон байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах. | БХЗГ | Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран хяналт, шалгалтын дагуух санал дүгнэлтийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж, 2015 оны 02 сарын 18-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлж, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг батлуулсан.<br>Биелэлт 100% | 100 | |
| 14 | 02_2010_39 Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим | 5. дамжин өнгөрөх тээвэр, угтуулан тавих нөхцөл, урьдчилгаа төлбөр, боомт ашиглалт, хөрөнгө оруулалт, борлуулалтын нөхцөлийн талаар хэлэлцээ хийж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой нэгдсэн компани /консорциум/-ийг | | Ерөнхий сайдын 2011 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 17 дугаар захирамжаар байгуулагдсан Таван толгой нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах нэгдсэн компани (консорциум)-ийг шалгаруулах урьдчилсан сонгон шалгаруулалтаар хураангуй жагсаалтад үлдсэн 6 оролцогчтой хэлэлцээ хийх баг өмнө нь Таван | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | асуудлын тухай | нээлттэй хэлбэрээр сонгон шалгаруулж хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлж, бусад баримт бичгийн төслийг танилцуулах. | | толгой төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж холбогдох гэрээний төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн боловсруулсан хөрөнгө оруулалтын болон нүүрс олборлолтын гэрээний төсөл дээр тулгуурлан УИХ-ын 39 дүгээр тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Ерөнхий сайдын 2011 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 17 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу дамжин өнгөрөх тээвэр, боомт ашиглалт, борлуулалт, хөрөнгө оруулалтын нөхцөл, урьдчилгаа төлбөр зэрэг асуудлыг тусгаж Таван толгой ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээний шинэчилсэн төслийг боловсруулсан. Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд холбогдох яамдуудыг өгсөн саналыг тусгаж Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд Засгийн газар гэрээний төслийг ҮАБЗ-д хүргүүлж, хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. ҮАБЗ энэ асуудлыг хэлэлцэхийг түр хойшлуулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 108 дугаар захирамжаар "Тавантолгойн ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах нэгдсэн компани-ийг шалгаруулах урьдчилсан сонгон шалгаруулалтаар хураангуй жагсаалтад үлдсэн оролцогчидтой УИХ болон Засгийн газраас тогтоосон нөхцөлийн дагуу хэлэлцээ хийх, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ч.Сайханбилэгээр ахлуулан байгуулж ажилласан.Монгол Улсын сайд М.Энхсайханаар ахлуулсан ажлын хэсгийн боловсруулсан гэрээний төслийг УИХ-аас томилсон ажлын хэсэг буцаасан. | | |
| 15 | 02_2009_45. Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал | "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан баталж, тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн | БХЗГ СБТГ | Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөл болон улсын төсвийн төсөлд тусган ажиллаж байна.<br>Биелэлт-100% | 100 | Хасах саналтай |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай | эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай. | | | | |
| **УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ** | | | | | | |
| 1 | 2015-04-22-06. Засгийн газарт чиглэл өгөх тухай | 1. МУ-ын Засгийн газрын "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" 2011 оны 175 дугаар тогтоол хууль, тогтоомжид нийцээгүй байх тул хуульд нийцүүлэн өөрчлөх эсхүл хүчингүй болгох | СБТГ, ГБХ | БХБЯ-наас "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" Засгийн газрын 2011 оны 175 дугаар тогтоолыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж танилцуулсан.<br>Биелэлт-100% | 90 | |
| 2 | | 2. Тогтоолын биелэлтийг 2015 оны хаврын чуулганы хугацаанд багтаан танилцуулах | СБТГ, ГБХ | Ажлын хэсгээс боловсруулсан Засгийн газрын тогтоолын төслийг БХБЯ-наас Засгийн газарт хүргүүлнэ. Биелэлт 100% | 90 | |
| 3 | 2015-04-08-10. Шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай | 1.1. УИХ-ын 2010 оны 39, 2012 оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах шуурхай арга хэмжээ авч, "Эрдэнэс тавантолгой" хувьцаат компаний хувьцааны эзэмшилийн бүртгэлийг баталгаажуулах ажлыг 2015 онд багтаан хэрэгжүүлэх | СБТГ | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны бүртгэлийг хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу бүртгэх, цэгцлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн хүрээнд холбогдох санал боловсруулж танилцуулсан. | 90 | |
| 4 | | 1.2. "Эрднэс таван толгой" хувьцаат компаний Хөгжлийн банкнаас авсан зээлийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах | СБТГ | Энэ асуудлыг “Эрдэнэс Монгол” ХХК хариуцна.<br><br>Үнэлгээгүй | /-/ | |
| 5 | | 1.3. Монгол улсаас экспортлох нүүрс, уул уурхайн бусад бүтээгдэхүүний тээвэрлэлтийн 50-иас доошгүй хувийг үндэсний тээврийн компани, консерциумаар гүйцэтгүүлэх | СБТГ | Монгол улсаас экспортлох нүүрс, уул уурхайн бусад бүтээгдэхүүний тээвэрлэлтийн 50-иас доошгүй хувийг үндэсний тээврийн компани гүйцэтгэж байна. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Биелэлт 100% | | |
| 6 | | 1.4. "Эрдэнэс таван толгой" ХК-ний ТУЗ-ын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хууль тогтоомжинд нийцэж байгаа эсэхийг хянан шалгаж, хууль тогтоомж зөрчсөн төрийн албан хаагчдад хариуцлага тооцож хохирлыг барагдуулах арга хэмжээ авах | СБТГ | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дүнг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанд танилцуулж, УИХ-ын зарим гишүүдээс гаргасан саналын дагуу ЭЗБХ-ны тогтоол гаргуулахаар тогтсон.<br>Биелэлт-90% | 90 | |
| 7 | | 1.5. Засгийн газарт болон "Эрдэнэс таван толгой" ХК, "Эрдэнэс монгол" ХХК-д эдийн засгийн байнгын хороо, Үндэсний аудитын газрын хамтарсан шалгалтын ажлын хэсгээс өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах | СБТГ | УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Үндэсний аудитын газраас "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Эрдэнэс Монгол" ХХК-д өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар холбогдох чиглэл өгч ажилласан. Тухайлбал, Тавантолгойн Цанхийн Зүүн уурхайн гэрээт олборлолтын ажлын хөлс болон нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үнийг бүрэн төлж барагдуулах талаар шуурхай арга хэмжээ авч ажиллах тухай албан тоот /2015.04.28-ны 1/1004/-ыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хүргүүлсэн.<br>Биелэлт-100% | 90 | |
| 8 | | 1.6. Энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг УИХ-ын 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах | СБТГ | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2015 оны 3 дугаар сарын хуралдаанд танилцуулсан.<br>Биелэлт-100% | 90 | |
| 9 | 2015-01-05. Засгийн газарт чиглэл өгөх тухай | 1.1. МУ-ын иргэдэд олгосон "Эрдэс Тавантолгой- ХК-ийн хувьцааг Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдах хүсэлт гаргасан боловч төлбөр төлөөгүй буюу хишиг хувь хүртээгүй иргэдийн хувьцааг буцаан эзэмшүүлэх, хөрөнгийн болон хувьцааны бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн цэгцэлж, нийт хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжүүдийн эзэмшлийн хувьцааг баталгаажуулах арга хэмжээ авах. | СБТГ | Монгол Улсын хувьцаа эзэмших боломжтой 2,744,333 иргэнд хувьцаа эзэмшүүлж, Засгийн газрын 2012 оны 201 дүгээр журмын дагуу 3842 аж ахуйн нэгжээс 105,256,725 ширхэг хувьцаа худалдан авах санал ирүүлсний 1523 аж ахуйн нэгж 28,8 тэрбум төгрөгийг хувьцааны төлбөр хэлбэрээр төвлөрүүлсэн. “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийн хувьцааг гурвалсан аргаар бүртгүүлэх бүтцийг урьдчилсан байдлаар сонгож IPO хийх үйл ажиллагааны хүрээнд Хадгаламжийн бичиг буюу DR гаргах талаар Хадгаламжийн банкаар Би Эн Уай Меллон (АНУ) банкыг сонгон шалгаруулж | 90 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | судалгаа хийлгэсэн. Биелэлт-90% | | |
| 10 | | 1.2. Эрдэнэс тавантолгой" ХК-ийн 1072 хувьцааг эзэмшиж буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувьцааны эдийн засгийн үр өгөөжийг хүртэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг Тавантолгой ордын хөрөнгө оруулагчтай хийх гэрээ, хэлэцээрт тусгайлсан бүлэг болгон тусггах | СБТГ | Тавантолгойн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгуулах Хөрөнгө оруулалт, Хамтын ажиллагааны гэрээний төсөлд Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 1072 хувьцааг эзэмшиж буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувьцааны эдийн засгийн үр өгөөжийг хүртэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг тусгах саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Биелэлт-100% | 100 | |
| 11 | | 3. Тогтоолын биелэлтийг 2015 оны хаврын чуулганы хугацаанд багтааж танилцуулах | СБТГ | УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг нарын гишүүдийн санаачилгаар Тавантолгойн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгуулах Хөрөнгө оруулалт, Хамтын ажиллагааны гэрээний төслүүдийг шинээр боловсруулж байна.<br><br>үнэлгээгүй | /-/ | |
| 12 | ӨБХ-09 Засгийн газарт чиглэл өгөх тухай 2014-12-17 | 1.1-1.4УУЯ, БОНХЯ-ны хариуцах заалт | | Биелэлт ирүүлээгүй | 0 | |
| 13 | 2011_01 Засгийн газарт чиглэл өгөх тухай | II.1.1МУ-ын Их Хурлын 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолын 3 дахь заалтын биелэлтийг хангах, АМТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг МУ-ын Засгийн газар /С.Батболд/-т чиглэл болгосугай. Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтаа нөхсний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлаар хөрөнгө оруулагч талтай байгуулсан гэрээний нөхцөлийг сайжруулах талаар | БХЗГ | Биелэлт ирүүлээгүй | 0 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэлэлцээ хийж шийдвэрлэх | | | | |
| **ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ** | | | | | | |
| 1 | 2015_77. Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элмент, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тухай | 2. Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элмент, газрын тосыг ашиглахтай холбогдсон бодлогын асуудлыг ҮАБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж байхыг Засгийн газарт чиглэл болгосугай. | БХЗГ ТБЗГ | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 77 дугаар зарлигаар 1995 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 39 дүгээр зарлигийг хүчингүй болгосноор газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг ҮАБЗ-д танилцуулан зөвлөмж гаргуулах шаардлагагүй болсон.<br>Биелэлт-100% | 100 | |
| 53 | 2014_211 Эрдэс баялгийн бирж байгуулах тухай 2014-06-28 | 2. Эрдэс баялгийн бирж байгуулах талаар дараах асуудлыг судалж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгаж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй: 1) түлхүүр гардуулах нөхцлөөр эрдэс баялгийн бирж байгуулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг 2014 оны III улиралд багтаан хэлэлцүүлэх; 2) эрдэс баялгийн биржийн үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг боловсруулан 2014 оны 9 дүгээр сард багтаан танилцуулах. | ЭЗСХОХ | Эрдэс баялгийн бирж байгуулахтай холбогдуулж түүний үйл ажиллагааны журам болон түлхүүр гардуулах нөхцлөөр эрдэс баялгийн бирж байгуулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг боловсруулан засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Мөн Монголын эрдэс баялгийн биржийн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулж, Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулаад байна. | 100 | |
| 54 | 2014_212. Журам батлах тухай | 3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндорж, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, Эрчим хүчний сайд М.Сономпил, Эрүүл мэндийн сайд Н.Удвал нарт даалгасугай. | | Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /зг-ын 2003-164-т/ ЗГ-ын 2014 оны 212 дугаар тогтоол нь Монгол бөхийн барилдааны дүрэм баталсан тогтоол байна. /Үнэлгээгүй/ | /-/ | |
| 55 | 2014_187. Концессын гэрээ байгуулах | 2. Концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нүүрс, ус хангамж, үнс зайлуулах, цахилгаан, дулааны шугам сүлжээнд холбох, төмөр зам, | ТБЗГ | Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлттэй уялдан нүүрс боловсруулах үйлдвэрийн асуудал чиг үүргийн хувьд Аж үйлдвэрийн яаманд шилжсэн, түүнчлэн өнөөгийн байдлаар Уул | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зөвшөөрөл олгох тухай | авто зам, бусад барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хянан баталгаажуулахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Эрчим хүчний сайд М.Сономпил, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгасугай. | | уурхайн яамнаас нүүрстэй холбоотой ямар нэгэн тусгай зөвшөөрөл олгохгүй байгаа болно.Биелэлт 100% | | |
| 56 | 2014_161 Төсвийн хөрөнгөөр барьсан зарим барилга байгууламжийн тухай 2014-05-21 | 1. “ДЦС-2” төрийн өмчит хувьцаат компанийг түшиглэн жилд 210,000 тонн хагас коксон түлш үйлдвэрлэх хүчин чадал бүхий цогцолбор байгуулах төслийн гүйцэтгэл, зардлын тооцоо, хөрөнгийн үнэлгээг Үндэсний аудитын газар, тусгай зөвшөөрөл бүхий хөндлөнгийн үнэлгээчээр үнэлүүлж улсын комисс хүлээн авах арга хэмжээг зохион байгуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Эрчим хүчний сайд М.Сономпил нарт даалгасугай. | ТБЗГ | Уул уурхайн сайдын 2014 оны 190 дүгээр тушаалаар “ДЦС-2 ТӨХК-ийг түшиглэн жилд хоёр зуун арван мянган (210000) тонн хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах төсөл”-ийн хүрээнд баригдсан шахмал түлшний цех, агуулах, шингэн шилний үйлдвэрийн барилга байгууламжийн гүйцэтгэлд дүгнэлт гаргаж ашиглалтад оруулах Улсын комиссыг байгуулсан. Энэхүү комисс нь Уул уурхайн яам, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын алба, Төрийн өмчийн хороо, Онцгой байдлын ерөнхий газар, Улсын архивын газар, Ашигт малтмалын газар, зураг төслийн Шифт ХХК, Аморе Интернэйшнл ХХК-иудын төлөөллөөс бүрдэж ажилласан. Уг комисс нь Техникийн комиссоос гаргасан шийдвэр болон холбогдох баримт бичгийг судлахын зэрэгцээ үйлдвэрлэлийн явц байдалтай танилцаж улмаар “ДЦС-2 ТӨХК-ийг түшиглэн жилд хоёр зуун арван мянган (210000) тонн хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах төсөл”-ийн хүрээнд баригдсан шахмал түлшний цех, агуулах, шингэн шилний үйлдвэрийн барилга байгууламжуудыг ашиглалтад авах тухай шийдвэр гаргаж ажилласан. Уул уурхайн яамнаас Засгийн газрын 2014.05.21-ний өдрийн 161 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр шат дараатай арга хэмжээ авч ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын 2014 оны | 90 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 161 дүгээр тогтоолын 4 дэх заалт болох "Төслийн хүрээнд баригдсан шахмал түлшний цехийн болон агуулахын барилга, шингэн шилний үйлдвэрийн барилга, нүүрс хүлээн авах, дамжуулах цехийн өргөтгөл зэрэг барилга байгууламжийг улсын комисс хүлээн авсны дараа төслийн гүйцэтгэлийн зөрүү мөнгийг уг төслийн гүйцэтгэгч “Аморе интернейшнл” ХХК-иар нөхөн төлүүлэх арга хэмжээ"-г авахаар төслийн гүйцэтгэгчтэй гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Эрдэс баялаг, эрчим хүчний яам /хуучин нэрээр/, “Аморе интернэйшнл” ХХК-ийн хооронд 2010 оны 07 дугаар сарын 09-ны өдөр байгуулсан 10/56 тоот бүхий "ДЦС-2 ТӨХК-ийг түшиглэн 210000 тонн хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор”-ын гүйцэтгэлийн гэрээг дүгнэх ажлын хэсэг 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Аж үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайд, Уул уурхайн сайдын 81/67/79тоот хамтарсан тушаалаар байгуулагдан гэрээг дүгнэсэн.<br>/Хэрэгжих шатанд 95%/ | | |
| 57 | 2014_147 Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай 2014-05-10 | 2.3 яамд, төрийн захиргааны болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах хоол хүнсний хангамж, цэвэрлэгээ, засвар, харуул хамгаалалт зэрэг нийтлэг үйлчилгээ үзүүлэх газруудыг нэгтгэх, зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх | ЭЗСХОХ | Уул уурхайн яаманд дараах үйлчилгээг Төрийн үйлчилгээ улсын үйлдвэрийн газартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Үүнд: Уул уурхайн яамны аппаратын санхүүгийн үйлчилгээ, няравын үйлчилгээ, засвар, харуул хамгаалалт, цэвэрлэгээ, бусад үйлчилгээнүүд. | 100 | |
| 58 | 05_2014_18 Дотоодын үйлдвэрлэгч дийг Дэмжих зарим арга хэмжээний тухай | 2. Тендерт оролцогчдод давуу эрх олгосон талаархи мэдээг худалдан авах ажиллагааны улирлын тайланд дэлгэрэнгүй тусган Сангийн яаманд тухай бүр хүргүүлж байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | ЭЗСХОХ | Уул уурхайн сайдын багцын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлж дотоодын барааны худалдан авалтын тайланг Аж үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажиллаж байна. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2014-01-28 | | | | | |
| 59 | 05_2013_98 Талбай нөөцөд авах, хайгуулын ажил хийх тухай 2013-03-16 | 2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан талбайд "Эрдэнэс МГЛ" ХХК-иар дамжуулан геологи хайгуулын ажил хийх асуудлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Ашигт малтмалын газрын дарга Г.Алтансүх, Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай. | ГБХ | 1. Улсын төсвийн хөрөнгөөр геологи, хайгуулын ажил хийх зорилгоор стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн орд орчмын 2 талбайг нөөцөд авсан.<br>2. Засгийн газрын 98 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, нөөцөд авсан талбайд хайгуулын ажил хийх ажлын төлөвлөгөөг баталгаажуулан улсын төсөвт тусгуулан ажиллах талаар “Эрдэнэс МГЛ” ХХК-нд албан бичиг хүргүүлсэн.<br>-“Эрдэнэс МГЛ” ХХК-аас нөөцөд авсан талбайнуудад АМТХ болон Газрын хэвлийн тухай хуульд заасны дагуу хайгуулын ажлыг 2013 оноос эхлүүлэхээр 600,0 сая төгрөг төлөвлөн гүйцэтгэсэн байна.<br>--УТХ-өөр Эрдэнэтийн ордын орчимд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн Улаантолгой-50 төслийг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн.<br>Эрдэнэтийн ордын хайгуулын ажлыг 2013-2014 онд "Южный" участокийн хэмжээнд нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажил Оюут талбайд хийгдсэн. Хаах саналтай. /Хэрэгжилт 100%/ | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 60 | 05_2013_100 Стратегийн ач холбодол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2013-03-16 | 6. Стратегийн ач холбогдол бүхий ураны Мардай, Дорнод, Гурван булагийн ордуудыг ашиглах боломж, нөхцөлийг судалж, төрийн эзэмшлийн хувь хэмжээ тогтоох, орд ашиглах гэрээний төсөл боловсруулан Засгийн газарт танилцуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Цөмийн энергийн газрын дарга Н.Тэгшбаяр, Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай. | | Стратегийн ач холбогдол бүхий Мардайн ураны орд нь ордын нөөцийн дахин тооцоог хийж эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан бөгөөд цаашид орд ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг батлуулсанаар ордыг ашиглах эрх зүйн үндэс бүрдэж төрийн эзэмшилийн хувь хэмжээг тогтоох талаар арга хэмжээг хэрэгжүүлнэ.<br>Дорнодын ураны ордыг эзэмшигч Хан ресорсез ХХК нь Монгол Улсын Засгийн газартай маргаан үүсгэж шүүхээр шийдвэрлүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 177 дугаар захирамжаар олон улсын арбитрын шүүхийн шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн газраас Канад Улсын хөрөнгө оруулалттай “Хан ресорсез” ХХК болон түүний хөрөнгө оруулагдчдад төлөх төлбөрийг барагдуулах арга замыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан.<br>Хан ресорсез ХХК-ийн нэхэмжилсэн мөнгийг ЗГ төлж барагдуулж дууссан болно.<br><br>- Гурванбулагийн ураны ордыг ашиглах боломж, нөхцөлийг судалж, төрийн эзэмшлийн хувь хэмжээ, хил хязгаарыг тогтоох, орд ашиглах гэрээний төсөл боловсруулах ажлыг Төрийн өмчийн хороо, Цөмийн энергийн газартай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.<br>- Мардайн ураны ордын нөөцийн дахин тооцоог ЭБМЗ-ийн хурлаар хэлцүүлж хүлээн авч улсын нөөцийн бүртгэлд бүртгэсэн. | 90 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 61 | | 8. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Зам, тээврийн сайд А.Гансүх, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Эрчим хүчний сайд М.Сономпил, Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар), "Эрдэнэс МГЛ" ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Сайнбуян нарт тус тус даалгасугай. | | Оюутолгой, Тавантолгой, Цагаансуварга зэрэг стратегийн ордуудын дэд бүтцийн асуудлуудаар холбогдох судалгаа хийгдсэн. Сайншандын аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд дээрх асуудлуудыг уялдуулах шаардлага байгаа. Тухайлбал, Зам харилцаа, эрчим хүчний болон усан хангамжийн асуудлуудыг эхний ээлжинд шийдвэрлэхээр холбогдох байгууллагууд хамтарсан Ажлын хэсгүүд байгуулан ажиллаж байна. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас төмөр замын суурь бүтцийн эхний санхүүжилтэд шаардагдах 200 сая ам.доллар, Тавантолгойн уурхайг түшиглэн барих 450 МВт-ын цахилгаан станцад шаардагдах 50 сая ам.долларын хөрөнгийг 2013 онд "Чингис" бондын эх үүсвэрээс гаргасан. Тавантолгойн ордыг түшиглэн барих цахилгаан станцын төслийн нэгжээс хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулсан. Гэрээний төсөлд холбогдох саналыг тусгасан. | 100 | |
| 62 | 2012_120. Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай | 43.6. Гурванбулаг, Дорнод, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт Дулаан-Уул, Зөөвч овоо ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна. | БХЗГ | 1. Дулаан-Уул, Зөөвч-Овоо ураны ордын талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Кожеговь" ХХК-д ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудлаар Цөмийн энергийн комисс, Тагнуулын ерөнхий газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын саналыг авсны үндсэн дээр Ашигт малтмалын газраас Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 26 дугаар тэмдэглэлийг үндэслэн Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 420, 421, 422 дугаар шийдвэрээр "Кожеговь" ХХК-д MV-018914, MV-018915, MV-018916 дугаартай цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон.<br>Мөн дээрх ашиглалтын тусгай ззөвшөөрөл хүссэн өргөдлийг Мон-Атом ТӨХХК, Арева Монгол ХХК нарын хамтран байгуулсан Арева майнз ХХК-д шилжүүлэх ажил явагдаж байна.<br>Дээрх асуудлаар Цөмийн энергийн комиссын | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | батламж гаргаагүй тул шийдвэрлэгдээгүй болно. Дулаан-Уул, Зөөвч-Овоо ураны ордуудыг ашиглах “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулаад байна.<br>2. Монгол Улсын Цөмийн энергийн газар /хуучнаар/, Бүгд Найрамдах Чех Улсын Үйлдвэр худалдааны яам хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, төрийн өмчит “Мон-Атом” ХХК болон “Ураниум Индастри” ХК хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын төрийн өмчит “Мон-Атом” ХХК, Бүгд Найрамдах Чех Улсын “Ураниум Индастри” ХК хооронд хамтарсан “Мон-Чех Ураниум” ХХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-г 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан.<br>Монгол, Канадын хамтарсан ”Гурвансайхан” ХХК-ийн нийт хувьцааны Канадын талын эзэмшиж байгаа хувьцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах талаар хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийн саналыг комиссын хуралдаанаар хэлэлцээд тус компанийн нийт хувьцааны 85 хувийг эзэмшиж байгаа “Дэнисон Майнс (Монголиа)” ХХК-ийн хувьцааг худалдан авах саналыг Бүгд Найрамдах Чех Улсын “Ураниум Индастри” ХК-д тавихаар шийдвэрлэсэн. Үүний дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулж, Цөмийн энергийн комиссын Ажлын алба, Бүгд Найрамдах Чех Улсын “Ураниум Индастри” ХК, Канад Улсын “Дэнисон Майнс” корпораци хооронд “Дэнисон Майнс (Монголиа)” ХХК-ийн 85 хувийн хувьцааг худалдан авахтай холбоотой асуудлаар 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.<br>“Гурвансайхан” ХХК-ийн Удирдлагын хороо 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж “Дэнисон Майнс (Монголиа)” ХХК-ийн эзэмшлийн хувьцааг “Ураниум Индастри” ХК-д шилжүүлэх талаар хувьцаа эзэмшигчдийн дунд | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 63 | | | | санал хураах, хувьцаа эзэмшигч “Мон-Атом” ХХК, Дэнисон Майнс (Монголиа)” ХХК-ийн зүгээс санал нэгтэйгээр хувьцаа шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Цөмийн энергийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасны дагуу тус компанийн Удирдлагын хорооны шийдвэрийг Цөмийн энергийн комиссын 2015 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батламжилсан.<br>3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 177 дугаар захирамжаар байгуулагдсан олон улсын арбитрын шүүхийн шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн газраас Канад Улсын хөрөнгө оруулалттай “Хан ресорсез” ХХК болон түүний хөрөнгө оруулагдчдад төлөх төлбөрийг барагдуулах арга замыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.<br>/Биелэлт 100%/ | | |
| | | 49.3. Зэсийн баяжмалыг боловсруулан цэвэр зэс үйлдвэрлэх технологийн сонголт хийж, үйлдвэрийн ТЭЗҮ-ийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар гүйцэтгүүлнэ. | СБТГ | Эрдэнэт үйлдвэрийн захиалгаар БНХАУ-ын Volanco, INFI компанид боловсруулсан зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг АҮЯ-ны дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлэсэн. Зэс хайлуулах үйлдвэрийн төслийн нэгжийг АҮЯ-ны дэргэд байгуулан ажиллаж байна. /Биелэлт 100%/ | 100 | |
| 64 | 05_2012_128 Талбай нөөцөд авах, хайгуулын ажил хийх тухай 2012-11-10 | 2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан талбайд "Эрдэнэс МГЛ" ХХК-иар дамжуулан геологи хайгуулын ажил хийх асуудлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Ашигт малтмалын газрын дарга Г.Алтансүх, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд даалгасугай. | ГБХ | “Эрдэнэс МГЛ” ХХК-иар дамжуулан геологи хайгуулын ажил хийх асуудлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахаар судалгаа хийгдсэн.<br>Эрдэнэтийн орд орчмын Хужирын гол М-48-100, Эрдэнэт ЗУ-З-1 М-48-90 зэрэг 2 талбайг нэмж нөөцөд авахаар тогтож Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 98 дугаар тогтоол гаргуулсан. Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрээс хайгуулын ажлыг хийж байгаа бөгөөд 2013-2014 онд 8 тэрбум төгрөгийг хайгуул, өрөмдлөг, геофизикийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Улсын төсвийн хөрөнгөөр 2014-2016 онд хэрэгжүүлэх 1:50000-ны масштабын Геологийн | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | зураглал ерөнхий эрлийн ажлын Улаантолгой-50 төслийг эхлүүлсэн. Төслийн ажил үргэлжлэн хэрэгжиж байна. /Биелэлт-100%/ | | |
| 65 | 2011_159 НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө батлах тухай 2011-05-18 | 2. Эрхлэх ажлынхаа хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн 2014 онд биелэлтийг нь гаргахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн үндэсний комисст зөвлөсүгэй. | | Уул уурхайн салбарт хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний төслийг бэлтгэж холбогдох газарт хүргүүлсэн. Уул уурхайн салбарын бизнес ба хүний эрх Олон Улсын бага хурлыг зохион байгуулсан. Эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлаар гаргасан нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийг 2014 онд гаргасан. | 90 | |
| **ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ** | | | | | | |
| 1 | 2016_28 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 28 дугаар тэмдэглэл | I. 2. Комиссын хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлахыг Уул уурхайн сайд бөгөөд тус комиссын Монголын хэсгийн дарга Р.Жигжидэд даалгав. | ГХАХ | Бүрэлдэхүүнийг батлаж, хуралд амжилттай оролцсон. | 100 | |
| 2 | 2016_24 2016 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр 24 дугаар тэмдэглэл | XI. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцээд асуудлыг дахин судалж, хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж Засгийн газарт оруулахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | БХЗГ | | /-/ | |
| 3 | | XY.7. 2. “Нью Коже” ХХК-ийг төрийн | | Засгийн газрын тогтоолын дагуу “Эрдэнэс | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | өмчийн оролцоотой “Арева майнс” ХХК-д нэгтгэсэнтэй холбогдуулан Дулаан уул, Зөөвч овоо, Өмнөд зэрэг цацраг идэвхт ашигт малтмалын ордын MV-018914, MV-018915, MV-018916 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрийг “Эрдэнэс Монгол” ХХК-иас санал авсны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрчлөхийг Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяад даалгав. | БХЗГ | Монгол” ХХК-иас санал авахаар хүргүүлсэн бөгөөд одоогоор санал ирээгүй болно. | | |
| 4 | 2016_22 2016 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 22 дугаар тэмдэглэл | XXYIII.4. Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хэлэлцээг цаашид үргэлжлүүлж, 2016 оны 4 дүгээр сард багтаан орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахыг Ажлын хэсэг (Р.Жигжид)-т даалгав. | БХЗГ | Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг ажиллаж байна. | 70 | |
| 5 | 2016_21 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр 21 дүгээр тэмдэглэл | XX.3. “Кожеговь” ХХК-ийн Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших цацраг идэвхт ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг тусгаарлан байгуулсан “Нью Коже” ХХК-ийн нэр дээр бүртгэх тухай саналыг Эрчим хүчний сайд Д.Зоригт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Кожеговь” ХХК-ийн Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Дулаан уул, Зөөвч овоо, Өмнөдийн цацраг идэвхт ашигт малтмалын ордын MV-018914, MV-018915, MV-018916 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг | БХЗГ | Эдгээр тусгай зөвшөөрлүүдийг Монгол төрийн оролцоот “Арева майнс” ХХК-д шилжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг тусгаарлан байгуулсан “Нью Коже” ХХК-ийн нэр дээр бүртгэх ажлыг Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулан шилжүүлсэн.<br>100% | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тусгаарлан байгуулсан “Нью Коже” ХХК-ийн нэр дээр холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэхийг Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяад даалгав. | | | | |
| 6 | | XX.4. “Гурвансайхан” ХХК-иас Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох хүсэлт гаргасан талаар Эрчим хүчний сайд Д.Зоригт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Дундговь аймгийн Баянжаргалан, Өлзийт сумдын нутагт орших 1017X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Хайрхан, Дорноговь аймгийн Даланжаргалан, Дундговь аймгийн Баянжаргалан, Өндөршил сумдын нутагт орших 1021X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Хараат, Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших 1018X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Гурвансайхан, Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян сумдын нутагт орших 1068X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Өлзийт зэрэг цацраг идэвхт ашигт малтмалын орд газрын ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Гурвансайхан” ХХК-д олгох асуудлыг зарчмын хувьд дэмжиж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяад даалгав. | БХЗГ | “Гурвансайхан” ХХК-ийн дээрх ордуудыг ашглах ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлүүдийг хүлээн авч Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулахад тус тусгай зөвшөөрлүүдийг олгохыг дэмжиж буй тэмдэглэл гаргасан байдаг бөгөөд үүний дагуу ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг олгох ажиллагааг явуулж байна.<br>50% | 50 | |
| 7 | 2016_20<br>2016 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр 20 дугаар | XXIII.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 оны худалдан авах ажиллагааны тайлан, хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнг Сангийн сайд Б.Болор Засгийн газрын гишүүдэд | ЭЗСХОХ | 1.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль дүрэм, зааврын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>2. Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тэмдэглэл | танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 1. Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, цаашид худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журам, зааврын дагуу хэрэгжүүлэх, 2015 оны үнэлгээгээр хангалтгүй дүн авсан албан тушаалтанд хариуцлага тооцож, дүнг 2016 оны 4 дүгээр сард багтаан Сангийн яаманд танилцуулах; 2. “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж, худалдан авах ажиллагааны улирлын тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж байх; 3. Монгол Улсын төсвийн тухай хуулиар баталсан урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийг 2016 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор зарлан, мөн оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор тендер шалгаруулалтыг зохион байгуулж дуусган, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн байх; 4. Тендер шалгаруулалтын урилгыг олон нийтэд зарлан мэдээлэхдээ оролцогч аж ахуйн нэгжүүд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах боломжийг бүрдүүлэн ажиллах. | | хэмжээний тухай Засгийн газрын 2014 оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, худалдан авах ажиллагааны тайланг Аж үйлдвэрийн яаманд хүргүүлээд байна.<br><br>3. 2016 оны 6 сарын байдлаар Уул уурхайн яамнаас зарлах 2 тендерийг зохион байгуулан, 1 тендерийг үнэлж гэрээг байгуулан, 1 тендерийг үнэлж байна.<br><br>4. Тендер шалгаруулалтын урилгыг олон нийтэд зарлан мэдээлэхдээ оролцогч аж ахуйн нэгжүүдэд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах боломжийг бүрдүүлэн ажиллах талаар зөвлөмжийг хүргүүлж, шилэн дансанд ил тодоор мэдээллээд байна. | | |
| 8 | 2016_18<br>2016 оны 03 дугаар сарын | XIX.3. “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д | | “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 28-ний өдөр 18 дугаар тэмдэглэл | тусгасан зорилт, арга хэмжээг 2015 онд хэрэгжүүлсэн явцын тухай “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасан зорилт, арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | Бүх газар | | | |
| 9 | | XIX.4.2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав: 2.1. зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой заах; 2.2. үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний биелэлтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй нь уялдуулан тайлагнах. | ЭЗСХОХ | Зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж, үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний биелэлтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй нь уялдуулан тайлагнаж байна. | 90 | |
| 10 | | XIX.5. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжилт нь удааширч байгаа зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Бүх газар | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжилт нь удааширч байгаа зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. | 100 | |
| 11 | 2016_15 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 15 дугаар тэмдэглэл | IY. Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатарын санаачлан боловсруулсан Шатахууны эрсдэлийн нөөцийн тухай хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу хууль санаачлагчтай тохиролцсоны үндсэн дээр хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулах ажлыг зохион байгуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | ТБЗГ | Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу УИХ-ын гишүүн Б.Гарамгайбаатарын өргөн барьсан Шатахууны эрсдлийн нөөцийн тухай хуулийн төслийг дахин шинэчлэн боловсруулж, яамдуудаас санал авахад бэлэн болгоод байна. | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | 2016_12 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 12 дугаар тэмдэглэл | XY. 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх явцад үүссэн зарчмын зөрүүтэй асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд үүрэг болгов. | ТБЗГ | Тогтоолын хэрэгжүүлэх хүрээнд Газрын тосны хайгуулын Ар булагXXIX талбайн БХГ-г шинээр батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэн батлуулсан.<br>Биелэлт 100% | 100 | |
| 13 | | XXIII.2. Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний жагсаалт баталсан Засгийн газрын 2015 оны 336, Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолуудын хэрэгжилтийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг энэ оны 3 дугаар сарын 7-ны дотор багтаан Худалдан авах ажиллагааны газарт баталгаажуулан хүргүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | ЭЗСХОХ | 2016 онд Худалдан авах ажиллагааны газраас гүйцэтгэгчийг нь сонгон шалгаруулах төсөл, арга хэмжээ байхгүй. | /-/ | |
| 14 | | XXIII.3. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн 2015 оны жилийн эцсийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. 1. Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, | ХШҮДАГ | УУЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд 2015 оны жилийн эцсийн хууль тогтоомжийн цаг хугацааны хувьд ач холбогдолгүй бөгөөд хэрэгжих боломжгүй болсон, мөн бүрэн хэрэгжсэн УИХ-ын тогтоолын 48 заалт, УИХ-ын байнгын хорооны тогтоолын 6 заалт, ЗГ-ын тогтоолын 54 заалт, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн 134 заалт, Ерөнхий сайдын захирамжийн 16 заалтыг хүчингүй болгуулах, хаах тухай саналыг жилийн эцсийн эрх зүйн актын тайлангийн хамт 2016.01.15-ны өдрийн 1/89 тоотоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уул уурхайн яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох эрх зүйн баримт бичгийг Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх, Олборлох үйлдвэрийн техник, | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу, шуурхай зохион байгуулах; 2. Үүрэг болгосон шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем” (www.unelgee.gov.mn)-д байршуулж, гарсан үр дүн, үр нөлөөг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитойгоор хяналт-шинжилгээ хийж үнэлэн тайлагнах; 3. 2015 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг, даалгаврыг биелүүлэх талаар онцгой анхаарч, хэрэгжсэн ажлыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д бүртгүүлж, хяналтаас хасуулах; 4. Хуульд заасан эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх. | | технологийн, Ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, Нийтлэг асуудал гэсэн 5 ангиллаар хяналтад авч нийт 268 шийдвэрийн 399 заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 27 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилт 92.5%, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх 49 шийдвэрийн 67 заалтын хэрэгжилт 94.6%, олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудлын 19 шийдвэрийн 19 заалтын хэрэгжилт 99.6%, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогын 87 шийдвэрийн 125 заалтын хэрэгжилт 96.6%, нийтлэг асуудлын 86 шийдвэрийн 154 заалтын хэрэгжилт 91.6%-ийн тус тус биелэлттэй, ерөнхий дүнгээр 95%-ийн биелэлттэй дүгнэж дүгнэлт санал зөвлөмж боловсруулж ажилласан. | | |
| 15 | 2016_10 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 10 дугаар тэмдэглэл | XYI.1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкнаас авах 42.0 (дөчин хоёр) сая ам.долларын зээллэгийн 85 хувь болох 35.0 (гучин таван) сая ам.долларын зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай асуудлыг Сангийн сайд Б.Болор Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтнуудад даалгав: 1.1. Азийн хөгжлийн | | Тус яаманд хамаарахгүй асуудал тул хасах | /-/ | Хяналтаас хасуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | банкнаас авах зээллэгийн зориулалт, санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, түүний эдийн засгийн үр ашгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж Сангийн яаманд яаралтай хүргүүлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайханд; | | | | |
| 16 | 2016_01 2016 оны 01 дүгээр сарын 4-ний өдөр 01 дүгээр тэмдэглэл | XXI. 3. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцээд Хууль зүйн сайдын саналыг тусган, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж танилцуулахыг Монгол Улсын сайд М.Энхсайханд даалгав. | | Тус яаманд хамаарахгүй асуудал байх тул хасах. | /-/ | Хяналтаас хасуулах |
| 17 | 2015_64. 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 64 дугаар тэмдэглэл | XIII.3. Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн байгуулах эрчим хүчний цогцолборыг нүүрсээр хангах талаар “Шинэ Шивээ” ХХК-тай хэлэлцээ хийж, тохиролцсон тохиолдолд тус компанитай 2015 оны IY улиралд багтаан зохих журмын дагуу хамтарсан аж ахуйн нэгж байгуулах арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайханд даалгав. | БХЗГ | Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн байгуулах эрчим хүчний цогцолборыг нүүрсээр хангах талаар “Эрдэнэс Монгол” ХХК нь “Шинэ Шивээ” ХХК-тай хэлэлцээ хийж, урьдчилсан тохиролцоонд хүрч хамтарсан компани байгуулахаар болсон. /Биелэлт 100%/ | 100 | |
| 18 | | XIII.3.2.Хамтарсан аж ахуйн нэгж байгуулсны үндсэн дээр “Шинэ Шивээ” ХХК-д холбогдох хууль тогтоомжийн дагуу тус ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг Ашигт малтмалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Үүрийнтуяад даалгав. | БХЗГ, АМГ | “Эрдэнэс Монгол” ХХК нь “Шинэ Шивээ” ХХК-тай хэлэлцээ хийж, урьдчилсан тохиролцоонд хүрсний үндсэн дээр Ашигт малтмалын газрын даргын тушаалаар“Шинэ Шивээ” ХХК-д холбогдох хууль тогтоомжийн дагуу тус ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон. /Биелэлт 100%/ | 100 | |
| 19 | 2015_55. 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдөр 55 дугаар | XXI. 1.3.Монгол Улсын 2016 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар | ТЗУГ, ГХАХ | Тогтоол гарснаас хойш төсвийн хөрөнгөөр гадаадад томилолт болон албан айлчлал бусад арга хэмжээнд яваагүй тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. /Биелэлт 100 %/ | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тэмдэглэл | хэлэлцэж байгаа болон Засгийн газар төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан албан ёсны айлчлал, чухал шаардлагатай хөрөнгө оруулалтын уулзалтаас бусад арга хэмжээнд оролцохгүй байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | | | | |
| 20 | 2015_53. 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр 53 дугаар тэмдэглэл | XYI. 5. Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагч талтай байгуулах гэрээний төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн хэлэлцээний явц, үр дүнгийн талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулсантай холбогдуулан хөрөнгө оруулагч талаас тавьж байгаа санал, нөхцөлийг тухай бүр танилцуулан уг хэлэлцээг ойрын хугацаанд дуусгах чиглэлээр ажиллахыг Ажлын хэсэг (Б.Бямбасайхан)-т даалгав. | СБТГ, ТЗУГ | Тус чиглэлээр хэлэлцээр үргэлжилж байна. Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагч талтай байгуулах гэрээний төслийг талуудын эрх тэгш байдлыг хангаж, консерциумаар /Япон, БНХАУ, МУ/ гэрээ байгуулах төслийг хүргүүлсэн боловч УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг зэрэг гишүүдийн санаачилгаар шинэчилсэн гэрээний төслийг боловсруулж байна. Энэ талаар Эрдэнэс МГЛ ХХК-ийн зүгээс ЗГ-т ажлын явцыг танилцуулж, мэдээллээр хангаж байна. Биелэлт 70% | 70 | |
| 21 | 2015_49. 2015 оны 08 дугаар сарын 31-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл | XIII.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов: 1.1. биелэлт удаашралтай байгаа 31 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.2. зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой заах | БҮХ ГАЗ-РУУД | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Уул уурхайн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 6 арга хэмжээг хяналтанд авч биелэлтэд хагас, бүтэн жилээр х/ш/ү *хийж ажилласан. Жилийн эцсийн байдлаар нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтын үйлдвэрийг ажиллуулж эхлэх* гэсэн арга хэмжээний биелэлт 50%-ийн биелэлттэй дүгнэгдсэн. Уг арга хэмжээг Япон улсын NEDO байгууллагын тусламжтайгаар хэрэгжихээр судалгааны ажил хийгдэж байна. Улсын төсвөөс санхүүжилт хийгдээгүй болно. | 50 | |
| 22 | 2015_43. 2015 оны 07 дугаар сарын 20-ны өдөр 43 дугаар тэмдэглэл | XY. 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлж авсан “Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК нь “Сансарын геологи хайгуул” ХХК-ийн 2014 онд төлөвлөсөн хайгуулын ажлыг 2015 онд багтаан нөхөн хийж | ТБЗГ | Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК нь “Сансарын геологи хайгуул” ХХК-ийн 2014 онд төлөвлөсөн хайгуулын ажлыг 2015 онд багтаан нөхөн хийж дуусгах, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төлөх зэрэг асуудлыг 3 талт гэрээ байгуулан ажиллаж | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дуусгах, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төлөх зэрэг асуудлыг 3 талт гэрээнд тусган хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэнд даалгав. | | байна.<br>Биелэлт 100% | | |
| 23 | | XXY. 1.Үүнтэй холбогдуулан Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, удаашралтай болон тасарч байгаа заалтын биелэлтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | ХШҮДАГ | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 2015 оны хагас жилээр 95,6%, жилийн эцсийн байдлаар 91,6%-ийн тус тус биелэлттэй дүгнэж тайланг ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан.<br>Биелэлт-100% | 100 | |
| 24 | 2015_39. 2015 оны 06 дугаар сарын 29-ны өдөр 39 дугаар тэмдэглэл | XXXII. Үндэсний хөтөлбөрүүдийн 2014 оны хэрэгжилтийн нэгдсэн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан эрхэлсэн асуудлын хүрээнд дэх зорилго, зорилт нь давхардаж байгаа хөтөлбөрүүдийг нэгтгэж, 2015 онд хэрэгжиж дуусах хөтөлбөрийн биелэлтэд үнэлгээ өгч, хэрэгжилт нь удааширсан буюу тасарсан хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар тодорхой санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. | ХШҮДАГ | ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолын дагуу хөтөлбөр төсөлд ХШҮ хийж, 2015 оны жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг яамны нэгдсэн тайланд хавсарган 2016 оны 03 сарын 30-ны өдрийн 1/585 албан тоотоор, ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 25 | | XXXII.7 Үүнтэй холбогдуулан 104 дүгээр уртрагийн зүүн талд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгон, нутгийн удирдлагатай нь зөвшилцсөний үндсэн дээр хайгуулын тусгай зөвшөөрлийг зохих хууль тогтоомжийн дагуу олгох арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | БХЗГ | Засгийн газрын 2014 оны 239 дүгээр тогтоолоор баталсан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайд зохих хууль тогтоомжийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа явагдаж байна. | 100 | |
| 26 | 2015_36 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 36 дугаар тэмдэглэл | XXXY.7.1 БНХАУ-ын Засгийн газраас олгосон 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэх Аймгуудын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах төсөл, Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төслийн худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, холбогдох бусад төслүүдийн Тусгайлсан зээлийн хэлэлцээрийг ойрын үед байгуулахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Уул уурхайн сайд Р.Жигжид, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт тус тус даалгав. | ЭЗСХОХ | Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төслийн нэгжийг татан буулгаад байна. | /-/ | |
| 27 | 2015_24 2015 оны 05 дугаар сарын 4-ний өдөр 24 дүгээр тэмдэглэл | XXI. 2. Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Сентерра гоулд Монголиа” ХХК-тай тус ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээний талаар хийж байгаа хэлэлцээний явцын тухай Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан уг хэлэлцээг 2015 оны 5 дугаар сарын 25-ны дотор дуусгахыг Ажлын хэсэг (Г.Тэмүүлэн)-т даалгав. | БХЗГ | Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг ажиллаж байна. | 50 | |
| 28 | 2015_23. | 2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга | ЭЗХОХ, | Замын-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 23 дугаар тэмдэглэл | хэмжээний чанар, хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлийг гаргуулан хянан баталгаажуулах, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах. | ХШҮДАГ | байгууламжийн автоматжуулалтын ажлыг амжилттай дуусгаж холбогдох комиссуудыг ажиллуулан төсвийн жилд багтаан хүлээн авч гүйцэтгэлийг Сангийн яаманд уламжлан санхүүжүүлж байна.<br>Биелэлт-100% | | |
| 29 | 2015_20. 2015 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр 20 дугаар тэмдэглэл | XXIY. 6.1.Оюутолгой төслийг үр дүнтэй хэрэгжүүлж, цаашид татвар, тайлан, балансай холбогдох маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Оюу толгой" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын хууль тогтоомж, стандарттай нийцүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон тус компанийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ганболд нарт; | СБТГ | "Оюу толгой" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын хууль тогтоомж, стандарттай нийцүүлэх талаар “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК хариуцан холбогдох арга хэмжээг авч, хяналт тавин ажиллаж байна. Биелэлт-70% | 70 | |
| 30 | 2015_18. 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 18 дугаар тэмдэглэл | XXII.2. Гацууртын ордын хөрөнгө оруулагчтай хийж байгаа хэлэлцээний явцын талаар Үүнтэй холбогдуулан хэлэлцээг эцэслэх чиглэлээр шуурхай ажиллаж, явц, үр дүнг тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | БХЗГ | Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг ажиллаж байна. | 70 | |
| 31 | 2015_16. 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл | XIII. 3. Уул уурхайн сайд Р.Жигжид Канад Улсад хийсэн ажлын айлчлалын талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан ажлын айлчлалыг үр дүнтэй болсон гэж үзэж, айлчлалын явцад хоёр талын хэлэлцэн тохиролцсон асуудлуудыг ажил хэрэг болгох талаар холбогдох арга хэмжээ | ТЗУГ, ГХАХ | Уул уурхайн сайд Р.Жигжид тэргүүтэй төлөөлөгчид 2015 оны 3 дугаар сарын 1-5-ны өдрүүдэд Канад Улсад ажлын айлчлал хийсэн. Ажлын айлчлалын хүрээнд Уул уурхайн сайд Р.Жигжид Канадын Сангийн сайд ноён Жо Оливер, Гадаад худалдааны сайд ноён Эд Фаст, Канадын Парламентын Нийтийн танхимын гишүүн, уул уурхайн асуудал эрхэлсэн парламентын Төрийн нарийн бичгийн дарга, сайд | 90 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | авч ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | | хатагтай Келли Блок, Канадын парламентын гишүүн ноён Грег Грове, Канадын экспортыг дэмжих байгууллагын тэргүүн дэд ерөнхийлөгч ноён Карл Бурлок, Уул уурхайн хайгуулч, олборлогчдын холбооны ерөнхийлөгч ноён Род Томас зэрэг Канадын төрийн байгууллагуудын удирдлагатай уулзаж харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.<br>Ажлын айлчлалын үеэр “Монгол Улсын Уул уурхайн яам, Канадын Байгалийн нөөцийн яам хооронд эрдэс баялаг, металлын салбарын тогтвортой үйл ажиллагааны хөтөлбөр”-т 2015 оны 3 дугаар сард гарын үсэг зурж баталгаажуулсан.<br>Хөтөлбөрт тусгасан 1 дэх заалтын хүрээнд 2015 оны 3 сараас хойш Уул уурхайн сайдын болон ТНБД, Газрын дарга нарын төвшинд олон чухал уулзалтуудыг Канадын талтай хийсэн ба уг уулзалтуудын мөрөөр тодорхой, бодитой ажлуудыг шийдвэрлэж ирсэн болно.<br>Монгол Улсад уламжлал болгон зохион байгуулагддаг уул уурхайн салбарын Дисковери Монголиа, Инвест Монголиа, Коал Монголиа, Майн Экспо зэрэг олон улсын хурал, чуулга уулзалтад Канадын талыг идэвхитэй оролцож байхыг уриалан ажиллаж байна.<br>Хөтөлбөрийн 2 дахь заалтын хүрээнд доорхи ажлууд хийгдсэн болно.<br>Үүнд: Монгол улс нь өнгөрөгч хугацаанд эрдэс баялгийн салбарын хууль эрх зүйн орчноо боловсронгуй болгох, хөрөнгө оруулалт татах таатай нөхцлийг бүрдүүлэх чиглэлд анхаарал хандуулж ирсэн. Үүнтэй холбоотойгоор олон улсын хандивлагч болон түнш байгууллагуудтай хамтран дараах чиглэлүүдэд тодорхой ахиц гаргав. Үүнд:<br>а) Тусгай зөвшөөрөл, кадастрын бүртгэлийн системийг бүрэн цахимжуулсан (Дэлхийн | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | банкны төсөл)<br>b) Ашигт малтмалын нөөц, баялгийн ангиллыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцүүлж шинэчлэн гаргасан. Нөөцийн тайланг боловсруулахад мөрдөх дүрэм журмыг олон улсын байгууллагын зүгээс тавигдах шаардлагуудад нийцүүлэн боловсруулсан. (Дэлхийн банк, Австрали улсын зөвлөх үйлчилгээ)<br>c) Уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалт, эдгээртэй холбоотой аюулгүй ажиллагааны дүрэм журмыг шинэчлэн боловсруулсан (Дэлхийн банкны төсөл)<br>d) Нутгийн иргэдийн оролцоо, орон нутгийн хөгжлийн асуудлаар холбогдох гэрээний загваруудыг боловсруулж бэлэн болгосон (Дэлхийн банк)<br>Уул уурхайн салбарт дэлхийд тэргүүлэгч Канад улстай ч мөн ижил байдлаар төр, засгийн түвшинд албан ёсны хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа болно. Хамтын ажиллагааг дараах чиглэлүүдээр хөгжүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна. Үүнд:<br>a) Уул уурхайн салбарын засаглалын тогтолцоог бэхжүүлэх, чадавхижуулах иж бүрэн хөтөлбөр<br>b) Уул уурхайн салбарын үндэсний сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулах<br>c) Үндэсний геологийн албыг байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх<br>d) Эрдэс баялгийн бирж байгуулахад хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих<br>e) Бичил уурхайг зохистой хэлбэрээр | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөгжүүлэх чиглэлээр туршлага судлах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг болно.<br><br>Канадын Засгийн газраас 2014 онд тусгайлан сонгосон "25 фокус улс"-ын нэгт Монгол Улс багтаж дэмжлэг туслалцаа авах болсон мөн Уул уурхайн сайдын 2015 оны 3 дугаар сард Канад Улсад хийсэн айлчлал, уулзалтууд, "Монгол Улсын Уул уурхайн яам, Канадын Байгалийн нөөцийн яам хооронд эрдэс баялаг, металлын салбарын тогтвортой үйл ажиллагааны хөтөлбөр", 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Монгол-Канадын Засгийн газар хоорондын зургаадугаар дугуй ширээний уулзалт зэрэг нь Канадын Засгийн газрын санхүүжилтээр Монгол Улсын Уул уурхайн салбарт 2015 онд томоохон хоёр төсөл эхлүүлэхэд томоохон түлхэц болсон болно.<br>1. "Монгол Улсад Олборлох Салбарын Удирдлагыг Бэхжүүлэх нь (SESMIM)" төсөл (2015-2020) нь Монгол улсын нийгмийн салбарын хүчин чадалыг нэмэгдүүлж, ил тод байдал болон үр дүнтэй бодлогыг хэрэгжүүлж, Олборлолтын салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.<br>2. "Институцийнөөрчлөлт хийх замаар төрийн эрдэс баялгийн менежментийг сайжруулах санаачлага" ТЭБМСС (MERIT) төсөл нь төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах арга замаар Монгол улсын олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой. /Биелэлт 90%/ | | |
| 32 | | XIII.4.1.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгох ажлын явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Засгийн газрын хуралдаанд хийх | ТЗУГ | Засгийн хуралдаанд хийх танилцуулгыг нэг загварт оруулан 7 хоног бүр танилцуулж байсан бөгөөд 6 сараас сард нэг удаа танилцуулахаар болсон. Тухай бүр танилцуулж байна./Биелэлт 100%/ | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 33 | | танилцуулгыг нэг загварт оруулан, 7 хоногийн хугацаанд гарсан өөрчлөлтийг харуулах боломжтой байдлаар бэлтгэн танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд; | | | | |
| | | XIII. 4.2. Засгийн газрын 2014 оны 239 дүгээр тогтоолын биелэлтийг хангах зорилгоор хүргүүлсэн санал авах мэдэгдлийн хариуг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай ирүүлж, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд зохих дэмжлэг үзүүлэн ажиллах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт чиглэл өгч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт нарт даалгав. | СБТГ, БХЗГ | 2015 оны 05 дугаар сарын 29-ны өдөр цахим хэлбэрээр, 2015 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаар, 2015 оны 12 дугаар сарын 17-ны Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын семинарын үеэр хайгуулын тусгай зөвшөөрөл олголтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг аймаг, нийслэлийн засаг дарга нарт хүргүүлсэн. /Биелэлт 100%/ | 100 | |
| 34 | | XIII. 6 Алтны олборлолтыг нэмэгдүүлж, эдийн засгийг эрчимжүүлэх талаар хийж байгаа ажлын явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн давхцалгүй талбайд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг сэргээж, алт олборлох үйл ажиллагааг эхлүүлэх арга хэмжээг шуурхай авч ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол нарт даалгав. | БХЗГ | БОНХАЖЯ-аас усны сан бүхий газрын хилийн заагийг тогтоон, тодорхойлолт гарган өгч байгаа ба дзавхцалгүй хэсэгт үйл ажиллагаа явуулах ААН-ийн ТЭЗҮ, 2015 оны уулын ажлын төлөвгөөг шуурхай батлах арга хэмжээ авч, ААН-үүдийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна.Давхалцалтай хэсгийг тогтоосон бөгөөд давхцалгүй талбайд үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 35 | 2015_14. 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл | XYII.Гадаадын зах зээлд борлуулсан төмрийн хүдэр, баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулан борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалыг батлах тухай асуудлыг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу төсөвт үзүүлэх нөлөөллийг нь тооцож, Сангийн яамаар хянуулсны үндсэн дээр хууль тогтоомжид нийцүүлэн дахин боловсруулж, Засгийн газрын дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | СБТГ | Гадаадын зах зээлд борлуулсан төмрийн хүдэр, баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулан борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалыг Засгийн газрын 2015 оны 103 дугаар тогтоолоор батлуулсан. /Биелэлт 100 %/ | 100 | |
| 36 | 2015_5 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр 05 дугаар тэмдэглэл | XYI. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарын семинарыг 2015 оны 2 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд зохион байгуулах тухай Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2015 оны улсын төсөв, санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга зам, эрхэлсэн салбар, хүрээний чиглэлээр баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар орон нутгийн удирдлагуудад нэгдсэн ойлголт, чиглэл өгч, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2015 онд хамтран ажиллах гэрээ байгуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | ТЗУГ | Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарын семинарыг 2015 оны 2 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд зохион байгуулах үеэр Уул уурхайн сайд танилцуулга хийж, хамтран ажиллах гэрээ байгуулсан. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 37 | 2015_4 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 04 дүгээр тэмдэглэл | XI. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлын үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав: 3.1. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын явц, үр дүнг жил бүр Засгийн газарт танилцуулж байх;<br>3.2. улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн талбайг улсын нөөцөөс чөлөөлөх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байх;<br>3.3. геологийн судалгааны ажлын үр дүнд тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байх. | | 1.Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлын үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хуралдаанд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байна. /Биелэлт-100%/<br><br>2.Засгийн газрын 2009 оны 86, 2010 оны 205, 2011 оны 372 дугаар тогтоолоор улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын талбайг улсын нөөцөд авсан. 2009-2011 онд нөөцөд авсан талбайнуудад төсвийн санхүүжилтээр геологийн судалгааны ажлыг хэрэгжүүлж дууссан бөгөөд эдгээр талбайг нөөцөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэн ажиллаж байна. Хэрэгжих шатанд -70%<br><br>3.Улсын төсвийн санхүүжилтээр 2009-2013 онд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайг ялган ашигт малтмалын кадастрын зураг зүйн болон мэдээллийн санд бүртгэсэн. Эдгээр талбайд АМТХ-ийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. /Хэрэгжих шатанд-90%/ | 100 | |
| 38 | 2015_1 2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр 01 дүгээр тэмдэглэл | XII. 3.1 иргэн, хуулийн этгээдээс шүүх, Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан хэрэг маргаан. хууль зөрчсөн шийдвэр гаргахгүй байх талаас онцгой анхаарч, хариуцсан ажлын хүрээнд хамаарах хэрэг, маргааныг шийдвэрлэх явцад Засгийн газрын итгэмжлэгдсэн | ТЗУГ | Тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллаж байна. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төлөөлөгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав; | | | | |
| 39 | 2014_63. 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 63 дугаар тэмдэглэл | IX. 1. Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Мянганы сорилтын сангийн 2 дахь компакт гэрээний хүрээнд Монгол Улсад төсөл хэрэгжүүлэх болсон талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.1. АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Мянганы сорилтын сангийн 2 дахь компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлэх боломжтой томоохон төслийн талаарх саналаа холбогдох материал, баримт бичгийн хамт бэлтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2015 оны 1 дүгээр сарын 15-ны дотор ирүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав. | СБТГ, ЭЗСХОХ | Биелэлт ирүүлээгүй | 0 | |
| 40 | 2014_51. 2014 оны 10 дугаар сарын 4-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл | XYI.Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг зөвшөөрч, холбогдох хуулийн дагуу үзэл баримтлалыг батлуулан хуулийн төслийг боловсруулж танилцуулах өргөтгөсөн ажлын хэсэг гарган ажиллуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгав. | СБТГ | "Газрын хэвлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ЕТГ, БХБЯ, БОНХАЖЯ-ны төлөөллийг оролцуулсан өргөтгөсөн ажлын хэсгийг сайдын 2015 оны 03 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Шинэчлэн байгуулсан Ажлын хэсэг уг хуулийн төслийг боловсруулаад байна. /Биелэлт 100 %/ | 100 | |
| 41 | 2014_50. 2014 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр 50 дугаар тэмдэглэл | YIII.1. Засгийн газрын хуралдааны 2014 оны эхний 9 сарын нэгдсэн мэдээллийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын хуралдаанаар 2014 онд хэлэлцүүлж шийдвэрлүүлэх асуудлын биелэлтэд хяналт тавьж эрчимжүүлж ажиллахыг сайд нарт даалгав | ТЗУГ | Засгийн газрын хуралдаанаар 2014 онд хэлэлцүүлж шийдвэрлүүлэх асуудлыг төлөвлөсөн хугацаанд тус яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна. /Биелэлт 100%/ | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 42 | | ҮIII.5. Дэлхийн эрчим хүчний мэдээллийн нэгдсэн сүлжээ байгууллага болох “Platts” компаниас үнийн мэдээлэл авах төлбөрийн хэмжээг эцэслэн тохиролцох гэрээ байгуулах асуудлыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Platts” компанитай гэрээ байгуулах, мэдээллийн үйлчилгээний төлбөрийг тодорхой эх үүсвэрээс төлөх асуудлыг судлан Засгийн газрын хуралдаанд дахин оруулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгав. | СБТГ | “Platts” компаниас төлбөртэй мэдээлэл авах шаардлагагүй гэж үзсэн. | /-/ | |
| 43 | | ҮIII.6 Монгол Улсын Ерөнхий сайдын 2014 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 40 дүгээр захирамжаар байгуулагдсан Оросын Холбооны Улсаас Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүнийг шугам хоолойгоор нийлүүлэх, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг онгоцны түлшээр хангах, газрын тосны хайгуулын ажилд оролцох зэрэг Оросын Холбооны Улсын Роснефть компанийн ерөнхийлөгч И.И.Сечиний тавьсан саналыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн танилцуулгыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Газрын тосны газар болон Роснефть компанийн хооронд 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан “Түлш, эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай протокол”-д тусгагдсан саналуудыг ажил хэрэг болгох талаар анхаарч ажиллахыг Ажлын хэсгийн дарга Г.Өлзийбүрэнд даалгав. | ТБЗГ | Ерөнхий сайдын 2014 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 40 дүгээр захирамжаар байгуулагдсан ОХУ-аас Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүнийг шугам хоолойгоор нийлүүлэх, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг онгоцны түлшээр хангах, газрын тосны хайгуулын ажилд оролцох зэрэг Роснефть компанийн ерөнхийлөгч И.И.Сечиний тавьсан саналыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. /Биелэлт 100%/ | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 44 | | ҮIII.7.1. Бага насны хүүхдийн эндэгдлийг бууруулахад улсын болон хувийн хэвшлийн бүх байгууллагуудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх, ахуйн зөв дадал зуршлыг хэвшүүлэх чиглэлээр ухуулга, мэдээллийн ажлыг өргөжүүлэх, салбарын бодлогодоо нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгаж ажиллахыг холбогдох яамдын сайд нарт даалгав. | ТЗУГ | Тус яамны чиг үүрэгт хамаарах асуудал байхгүй./Үнэлгээгүй/ | /-/ | |
| 45 | 2014_46<br>2014 оны 8 сарын 28-ний 46 дугаар тэмдэглэл | 1.2автобензин, дизелийн түлшний хангамж болон дотоодын жижиглэн худалдаалах үнийг тогтвортой байлгах талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг илүү оновчтой, шинэлэг болгох санал боловсруулж Засгийн газарт оруулах | ТБЗГ | Автобензин, дизелийн түлшний хангамж болон дотоодын жижиглэн худалдаалах үнийг тогтвортой байлгах талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг илүү оновчтой, шинэлэг болгох санал боловсруулах ажлын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-171/46 дугаар хамтарсан тушаалаар “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр (SIFS)”-ийг батлан гурван жилийн хугацаандамжилттай хэрэгжүүлсэн. SIFS дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээг Газрын тосны газартай байгуулсан, тусгай зөвшөөрөл эзэмшигч, жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 14 шатахуун импортлогч аж ахуйн нэгжийн санхүүжилтийн өртгийг бууруулах, санхүүгийн үүсмэл хэрэгсэл хийхэд төгрөгийн нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор 2012 – 2015 оны хооронд давхардсан дүнгээр нийт 226.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг УУЯ-наас ирүүлсэн хуваарилалтад үндэслэн оролцогч банкуудад олгосон нь 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдөр бүрэн төлөгдөж дуусаад байна. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд шатахуун импортлогч компаниудын эргэлтийн хөрөнгийн дутагдал, валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалсан шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ өсөх | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрсдэлийг бууруулж, түлш шатахууны үнийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүллээ. Тухайлбал, хөтөлбөр эхлэхээс өмнө буюу 2010-2012 онд шатахууны жижиглэнгийн үнэ литр тутамдаа дунджаар 100 төгрөгөөр нэмэгдэж байсан бол дэд хөтөлбөр хэрэгжих хугацаанд харьцангуй тогтвортой байсан. Биелэлт 100 хувь | | |
| 46 | 2014_38 2014 оны 7 сарын 9-ний 38 дугаар тэмдэглэл | ХҮII.3 Шивээхүрэн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг өргөтгөж, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай Уул уурхайн сайд Д.Ганхуяг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Нарийнсухайтын нүүрсний бүлэг ордоос Шивээхүрэн боомтоор тээвэрлэх нүүрсний хэмжээг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хилийн боомтоор нэвтрэх авто машины ачааллыг бууруулах, хоёр улсын хилийн гаалийн хамтарсан хяналт хийх боломжийг бүрдүүлэхтэй холбогдуулан нүүрс экспортлогч компаниуд болон нүүрс шилжүүлэн ачих байгууламж, зам барьж байгаа аж ахуйн нэгжүүдтэй тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Зам, тээврийн сайд А.Гансүх, Гадаад харилцааны сайд Л.Болд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг нарт даалгав. | ТБЗГ | Нарийнсухайтын нүүрсний ордод үйл ажиллагаа явуулж байгаа нүүрс экспортлогч компаниуд болон нүүрс шилжүүлэн ачих байгууламж, зам барьж байгаа аж ахуйн нэгжүүдтэй холбогдож, Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэх тогтоолын төслийг боловсруулж, холбогдох яамдуудаас санал авахаар албан бичгийн төсөл боловсруулагдсан байгаа. Шивээхүрэн боомтод 159 га бүхий нүүрс ачих, буулгах байгууламжийг хувийн хэвшлийн 20 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Энэхүү байгууламж нь одоогийн байдлаар хил, гааль, мэргэжлийн хяналт, боомтын захиргааны нийт 85 хүн ажиллах шаардлага хангасан оффис болон амрах байртай, цахилгаан дулааны дэд бүтэц бүрэн хийгдсэн, интернетийн сулжээ бухий,гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх боломжтой. Байгууламжийн хүчин чадлыг жилд 40 сая тонн нүүрс хүлээн авах, хадгалах, ачих боломжтой, хүрээлэн буй орчинд ээлтэй шийдлүүдтэй байхаар төлөвлөгдсөн. Дээрх байгууламжийг 2015 онд ашиглалтанд өгөх зорилготой ажиллаж байгаа бөгөөд, агуулахаас шууд вагон руу ачих, экспортолж буй нүүрсэнд Монгол, Хятадын гаалийн байгууллагууд хамтарч үзлэг хяналт хийх боломжийг бүрдүүлж, Хятадын талд шилжүүлэн ачихгүйгээр Хятадын нутаг дэвсгэрээр шууд тээвэрлэх боломж бүрдэх юм. | 50 | |
| 47 | 06_2014_16. 2014 оны 04 дүгээр сарын | Ү.2. Яамдаас боловсруулж байгаа хуулийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар | ТЗУГ | Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшөөрсний | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 19-ний өдрийн 16 дугаар тэмдэглэлд | хэлэлцүүлэн зөвшөөрөл авч байхаар тогтож, хуулийн төслийн үзэл баримтлал Засгийн газраар зөвшөөрөгдсөний дараа хуулийн төслөө боловсруулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | | дараа хуулийн төслийг боловсруулж байна. /Биелэлт 100%/ | | |
| 48 | 06_2014_10. 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 10 дугаар тэмдэглэлд | IX.Монгол Улсын худалдааны бодлогын талаарх Засгийн газрын тайлангийн төслийн тухай (Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр танилцуулав) Монгол Улсын худалдааны бодлогыг Дэлхийн худалдааны байгууллагад хянуулахтай холбогдуулан боловсруулсан Засгийн газрын тайлангийн төслийг хэлэлцээд сайшаан дэмжиж, уг хянуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | ЭЗХОХ, ТЗУГ | Монгол Улсын худалдааны бодлогыг Дэлхийн худалдааны байгууллагад хянуулахтай холбогдуулан боловсруулсан Засгийн газрын тайлангийн төслийг хэлэлцэхэд санал өгч дэмжлэг үзүүлж ажилласан./Биелэлт 100%/ | 100 | |
| 49 | 06_2014_09. 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 09 дүгээр тэмдэглэлд | XIY.2.1. Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх, иргэдийг чирэгдүүлэхгүй байх, хуулийн хугацаанд иргэдэд хариу өгч хэвших | ТЗУГ | Уул уурхайн яаманд 2016 оны эхний хагас жилд нийт 101 өргөдөл, гомдол ирүүлснээс 70 өргөдөлийг хугацаанд нь шийдвэрлэж 31 нь хяналтын явцдаа байна. Шийдвэрлэлт 70 | 70 | |
| 50 | | XIY.2.3. Өргөдөл гомдлын асуудлаар албан хаагчдад сургалт зохион байгуулах, асуудал хариуцсан албан хаагчдын ур чадварыг сайжруулах.”гэжээ. | ТЗУГ | Уул уурхайн яамны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд жил бүр архив, бичиг хэргийн сургалт мэдээлэлийг өгөх талаар оруулж байна. 2016 онд Удирдлагын академийн багш Б.Эрдэнэбаатараар сургалт, мэдээллийг хийсэн. /Биелэлт 100%/ | 90 | |
| 51 | 06_2014_08. 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар | XXI.2. Монгол Улсын сайд Н.Алтанхуягийн Орхон аймагт ажилласан дүнгийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг | БХЗГ | 2015 оны 5 сард оношилгооны төвийг нээж, ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.<br>Менежментийн гэрээгээр Японы 100 хувийн хөрөнгө оруулалттай “Медипасс” ХХК-нд шилжүүлэн өгсөн байна. /Биелэлт 100%/ | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тэмдэглэлд | Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Эрдэнэт Медикал" оношилгооны төвийг 2014 оны 11 дүгээр сард багтаан ашиглалтад оруулахыг "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн ерөнхий захирал Ц.Даваацэрэнд даалгав. | | | | |
| 52 | 2013_55 2013 оны 11 сарын 30-ны 55 дугаар тэмдэглэл | XX1.7 Монгол орны зүүн болон говийн бүсийн экологийн чухал ач холбогдол бүхий газрыг тодорхойлсон судалгааны ажлын үр дүнгийн талаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан судалгааны ажлыг үргэлжлүүлэн баруун болон төвийн бүс нутгуудад зохион байгуулахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нарт даалгав | | Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй асуудал байна. | /-/ | |
| 53 | 06_2013_32 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар тэмдэглэлд | XIII. 2. "Газрын тосны олборлолт, экспортыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX талбайгаас Монгол, Хятадын хилийн Баянхошуу боомтын чиглэлд 210,7 км хатуу хучилттай авто зам барих ажлыг шуурхай зохион байгуулж, холбогдох зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож ажиллахыг Зам тээврийн сайд А.Гансүх, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нарт тус тус даалгав. | ТБЗГ | Хатуу хучилттай замын 50 гаруй км далангийн ажил хийгдсэн. Үлдсэн хэсгийн гүйцэтгэгчийг сонгох асуудал ЗТЯ-аас зөвшөөрөл олгогдохгүй байгаагаас хойшлогдож байна. УУЯ, ГТГ-ын зүгээс шалтгаалах зүйл байхгүй бөгөөд ажлыг шуурхайлах талаар хүсэлтийг удаа дараа ЗТЯ-нд хүргүүлсэн.<br>Биелэлт-90% | 90 | |
| 54 | 2012_24 2012 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл | 10.1Бичил уурхайн үйл ажиллагааны хамрах нутаг дэвсгэрийн хүрээ, бичил уурхайчдын тоог харгалзан сумын батлагдсан орон тоо, төсөвт нь багтаан Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцэд бичил | | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагсантай холбогдуулан орон нутагт уг асуудлыг хариуцсан ажилтантай болох асуудлыг Уул уурхайн сайд болон Аймгийн Засаг дарга нарын хамтын ажиллагааны гэрээнд тусган хэргэжүүлж байна. | 90 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | уурхайн асуудлыг тодорхой ажилтанд хариуцуулан ажиллуулах арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд Д.Хаян хярваа, аймаг, сумдын Засаг дарга нарт даалгав. | | | | |
| **ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ** | | | | | | |
| 1 | 2016_26 Ажлын хэсэг байгуулах тухай Стратегийн ач холбогдол бүхий Гацууртын алтны үндсэн орд | 2. Хэлэлцээний явц, үр дүн, орд ашиглах гэрээний төслийн талаар тухай бүр Засгийн газарт танилцуулж, гэрээг 2016 оны 4 дүгээр сард багтаан байгуулах ажлыг удирдан зохион байгуулахыг Ажлын хэсэг (Р.Жигжид)-т даалгасугай. | БХЗГ | Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг ажиллаж байна. | 100 | |
| 2 | 2015_165. Ажлын хэсэг байгуулах тухай | 2. Хэлэлцээний явц болон үр дүн, гэрээний төслийн талаар тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Ажлын хэсэг (Б.Бямбасайхан)-т даалгасугай. | СБТГ | Хэлэлцээний явц болон үр дүн, гэрээний төслийн талаар тухай бүр Засгийн газарт Ажлын хэсэг тухай бүр танилцуулж байсан. /Биелэлт 100%/ | 100 | |
| 3 | 08_2014_61. Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай | 1. Нээлттэй засгийн түншлэлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих, нэгтгэн дүгнэх үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, яам бүрт ажиллах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, орон нутгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар, иргэний нийгмийн байгууллагын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай. | СБТГ, ЭЗХОХ | Үндэсний зөвлөл салбар зөвлөлийн ажлыг нэгтгэж тайлагнах тул яамнаас биелэлт гаргах шаардлагагүй.<br>"0" | /-/ | Хяналтаас хасуулах |
| 4 | | 2. Нээлттэй засгийн түншлэлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, | СБТГ, ЭЗХОХ | Үндэсний зөвлөл салбар зөвлөлийн ажлыг нэгтгэж тайлагнах тул яамнаас биелэлт гаргах шаардлагагүй. | /-/ | Хяналтаас хасуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нарийн бичгийн даргад даалгасугай | | "0" | | |
| 5 | 08_2014_56. Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай | 2. Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Засгийн газраас 100 хоногийн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг хангах ажлыг зохион байгуулж, биелэлтийг 7 хоног тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Эдийн засгийг эрчимжүүлэх зөвлөл (Н.Алтанхуяг)-д даалгасугай. | БҮХ ГАЗРУУД | Засгийн газраас 100 хоногийн хугацаанд ТБЗГ-аас авч хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг нэгтгэн гаргаж, ТЗУГ-т хүргүүлсэн. Ашигт малтмалын газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн а-44 дугаар тушаалаар батлагдсан Шинэчлэлийн Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоног” ажлын хүрээнд салбарын эдийн засгийн статистик мэдээллийг 7 хоног бүр тогтмол гаргаж байх ажлын эхлүүлсэн. Уг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд УУЯ, АМГ, салбарын томоохон холбоодын төлөөлөл орж ажилласан бөгөөд Уул уурхайн сайдын 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 125 дугаар тушаалаар баталсан компаниудын олборлолт экспортын төлөвлөгөөний биелэлтийг 7 хоног бүрээр гаргаж танилцуулж ажилласан. Засгийн газрын 322 дугаар тогтоолын дагуу Эдийн засгийг эрчимжлийг нэмэгдүүлэх "ЭЗЭН-100" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгсөн. Эдийн засгийг эрчимжлийг нэмэгдүүлэх "ЭЗЭН-100" хөтөлбөрийн хүрээнд УУЯ-ны хэрэгжүүлсэн 15 ажлын явцад 2014 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар хяналт, шинжилгээ үнэлгээ хийж ЗГХЭГ-т 2014 оны 08 дугаар сарын 18-ны өдөр хүргүүлсэн байна. /Биелэлт 100 %/ | 100 | |
| 6 | 08_2014_55. Ажлын хэсэг байгуулах тухай | 1. Монгол, Канадын хамтарсан "Гурван сайхан" ХХК-ийн нийт хувьцааны Канадын талын эзэмшиж байгаа хувьцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах хэлэлцээр хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай: | БХЗГ | Монгол, Канадын хамтарсан ”Гурвансайхан” ХХК-ийн нийт хувьцааны Канадын талын эзэмшиж байгаа хувьцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах талаар хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийн саналыг комиссын хуралдаанаар хэлэлцээд тус компанийн нийт хувьцааны 85 хувийг эзэмшиж байгаа “Дэнисон Майнс (Монголиа)” ХХК-ийн хувьцааг худалдан авах саналыг Бүгд Найрамдах Чех Улсын “Ураниум Индастри” ХК-д тавихаар | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | шийдвэрлэсэн. Үүний дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулж, Цөмийн энергийн комиссын Ажлын алба, Бүгд Найрамдах Чех Улсын “Ураниум Индастри” ХК, Канад Улсын “Дэнисон Майнс” корпораци хооронд “Дэнисон Майнс (Монголиа)” ХХК-ийн 85 хувийн хувьцааг худалдан авахтай холбоотой асуудлаар 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.<br>“Гурвансайхан” ХХК-ийн Удирдлагын хороо 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж “Дэнисон Майнс (Монголиа)” ХХК-ийн эзэмшлийн хувьцааг “Ураниум Индастри” ХК-д шилжүүлэх талаар хувьцаа эзэмшигчдийн дунд санал хурааж, хувьцаа эзэмшигч “Мон-Атом” ХХК, Дэнисон Майнс (Монголиа)” ХХК-ийн зүгээс санал нэгтэйгээр хувьцаа шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Цөмийн энергийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасны дагуу тус компанийн Удирдлагын хорооны шийдвэрийг Цөмийн энергийн комиссын 2015 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батламжилсан.<br>Биелэлт 100% | | |
| **ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ** | | | | | | |
| 1 | 2015-04/03. Таван толгойн талаар авах зарим арга хэмжээний талаар | 1. Таван толгойн хөрөнгө оруулалтын гэрээг Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн байгуулах | ТБЗГ | “Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн зарчим, удирдамж батлах тухай” УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоол, “Тавантолгойн ордыг ашиглах зарим асуудлын тухай” УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолуудыг удирдлага болгон Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын дагуу Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ашиглах Хөрөнгө оруулалтын болон бусад дагалдах гэрээний төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлэхээр Засгийн газраас өргөн барьсан.<br><br>Улсын Их Хурлын даргын 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 101 дүгээр захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын | 100 | |
| 2 | | 2. Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээний яриа хэлэлцээг МУ-ын ҮАБ-ын үзэл баримтлалд тодорхойлсон гадаадын хөрөнгө оруулалтын тэнцвэртэй байдлыг хангах, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хөшүүрэг болгох, тодорхой салбарт эдийн засгийн дунд, урт хугацааны зорилтыг хангахад чиглүүлэх | ТБЗГ | | 90 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | | 3. Тавантолгойн ордыг ашиглах асуудлаар өмнө гаргасан Улсын Их Хурал, ЗГ-ын тогтоол, шийдвэрийн уялдааг сайжруулах, төслийн үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд саадгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах | ТБЗГ | тогтоолын төсөл, Тавантолгойн ордыг хөгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ болон хавсралт гэрээнүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэгээр ахлуулан байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд: УИХ-ын гишүүн Су.Батболд, Д.Ганхуяг, А.Бакей, О.Баасанхүү, М.Сономпил, С.Ганбаатар, Д.Сумъяабазар, Б.Чойжилсүрэн, Б.Наранхүү нар орсон.<br><br>Тус Ажлын хэсэг “Тавантолгойн ордтой холбоотой гэрээ нь тухайн асуудлаар гарсан УИХ-ын болон холбогдох Байнгын хороодын тогтоолтой нийцэж байгаа эсэх”, “Гэрээ нь Үндэсний Аюулгүй байдлын Үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Зөвлөмж, Засгийн газрын холбогдох шийдвэр болон төрийн эрх бүхий байгууллагын бусад шийдвэртэй нийцэж байгаа эсэх”, “Гэрээ нь Монгол Улсын баримталж буй гуравдагч хөршийн бодлоготой нийцэж байгаа эсэх”, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 1072 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа иргэд болон үндэсний аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг хангаж байгаа эсэх” зэрэг нийт 14 зүйл заалт бүхий удирдамжийн хүрээнд санал, дүгнэлт гаргасан.<br><br>Тавантолгойн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээ, Хамтын ажиллагааны гэрээ, Концессын гэрээний төслүүдэд Уул уурхайн яамнаас Ажлын хэсэгт оролцсон төлөөлөл саналаа өгч байсан бөгөөд дээрх Ажлын хэсэгт ч холбогдох саналаа хүргүүлсэн болно.<br>Тавантолгойн ордын хөрөнгө оруулагч талууд /БНХАУ-ын Шиньхуа Энержи, Монголын Энержи Ресурс болон Японы Сумитомо корпораци/-тай байгуулах гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний явц, үр дүнг тухай бүр | 90 | |
| 4 | | 4. Монгол Улсын иргэдэд олгосон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг эдийн засгийн эргэлтэнд оруулж, хувьцааны ногдол ашиг хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах | ТБЗГ | | 90 | |
| 5 | | 5. Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээний явц, үр дүнг УИХ-д болон олон нийтэд танилцуулж ажиллах | ТБЗГ | | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажилласан. Мөн УИХ-ын 40 гаруй гишүүд “Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад байна. | | |
| 6 | 2014_46/26. Олон улсын гэрээ байгуулах үйл ажиллагааг сайжруулах тухай | 1. Улс хоорондын болон Засгийн газар хоорондын гэрээ байгуулахдаа дараах журмыг чанд баримтлах: 1.1.Гэрээ байгуулахдаа үндэсний язгуур ашигсонирхолыгүндэс болгох; 1.2.Гэрээг Үндсэн хууль болон бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд нийцүүлэх; 1.3.Гадаад харилцааны сайд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дугаар хэсгийн 4-т заасны дагуу гэрээ байгуулах чиглэлээр үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, гол хариуцлага хүлээх; 1.4.Тодорхой гэрээ байгуулах асуудлаар Гадаад харилцааны яамтай зөвшилцөн төсөл, орчуулгыг нь албан ёсоор хянуулж дүгнэлт гаргуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байх; 1.5.Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5.10, 5.11-д заасныг баримтлан гэрээний төслийг заавал монгол хэлээр үйлдэх. 2.Байгууллага хоорондын гэрээ байгуулахдаа Гадаад харилцааны яамны санал, дүгнэлтийг авч, байгуулсан гэрээг Гадаад харилцааны яаманд бүртгүүлэх. 3.Гэрээ байгуулахаар яриа хэлэлцээ хийхдээ "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай" Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01/01 дүгээр зөвлөмж | ТЗУГ | Гэрээ, санамж бичиг /3/-ыг байгуулахдаа холбогдох журмыг баримталж, Гадаад хэргийн яам, Хууль зүйн яам зэрэг холбогдох яамдаас санал авч, саналыг тусгаж, хамаарал бүхий хуулийг мөрдлөг болгож ажилласан. Биелэлт 100% | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | болон Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-ыг мөрдлөг болгох. | | | | |
| 7 | 2012_33/25. Газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах тухай | 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуулын Сүхбаатар-XX/11 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг "Вульф Петролеум" компанид олгох. | ТБЗГ | Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газрын тосны газар, “Вульф петролеум” ХК-ийн хооронд 2013 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Биелэлт-100% | 100 | |
| **ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ** | | | | | | |
| 1 | 2014_65/38. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах тухай | 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг "Хонгконг Вэлпэк Индастриал" ХХК, "Монгол Гладвилл Увс Петролеум" ХХК-д олгох. | ТБЗГ | Газрын тосны “Увс I” талбайд уламжлалт газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах “Монголиа Гладвилл Увс Петролиум” ХХК-д УУСайдын 2015 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 113 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.<br>Биелэлт-100% | 100 | |
| 2 | 2014_32/14. "Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх төсөл"-ийн тухай | 1. БНХАУ-тай "нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхдээ Монгол Улс, БНХАУ-ын хоёр талын хувь оролцоо адил тэнцүү хэмжээтэй байх, талууд өөрт оногдох оролцооны хүрээнд хөрөнгө оруулагч, мэргэжлийн багийг татан оролцуулах эрх нээлттэй байх зарчмыг баримтлах. | ТБЗГ | Монгол Улсын Уул уурхайн яам болон БНХАУ-ын Синопек корпорацийн хооронд “Монгол Улсад нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох төсөл хэрэгжүүлэх тухай” санамж бичиг байгуулсан.Энэхүү Санамж бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 74 дүгээр тогтоолоор Уул уурхайн яамны дэргэд “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх” төслийн нэгжийг байгуулсан бөгөөд 2014-2015 оны хооронд БНХАУ-ын Синопек корпорацитай хамтран Монгол Улсын зүүн бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн нүүрснээс синтетик байгалийн хийн үйлдвэр байгуулах, хий экспортлох төслийн урьдчилсан Техник эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/-ийг боловсруулсан.Нийт 36 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | шаардагдаж, 11000 байнгын ажлын байр бий болгох энэхүү төслийг Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаас гаргасан зөвлөмжөөр Монгол, Хятадын хамтарсан компани байгуулж гэрээний талууд ижил тэнцүү хувь оролцоотой байх, хийн болон ус дамжуулах хоолойн дэд бүтцийг Монгол Улсын төр 100 хувь эзэмших зарчмаар ажиллахыг чиглэл болгосон. Үүний дагуу саналыг БНХАУ-ын талд тавьсан боловч хүлээн авах боломжгүй хэмээн уулзалт, ярилцлагадаа удаа дараа тэмдэглэсэн тул хамтран ажиллах гэрээний өөр хувилбаруудыг судалж үзэхээр хоёр тал тохиролцсон. Биелэлт-100% | | |
| 3 | | 2. Нүүрс боловсруулах химийн үйлдвэрүүдийг ажиллуулахад шаардлагатай дэд бүтэц болох хий болон ус дамжуулах хоолойг 100 хувь төрийн эзэмшилд байлгах зарчмыг баримтлах. | ТБЗГ | Үүний хүрээнд төслийн нэгж 2014 онд БНХАУ-ын Синопек компанитай хамтын ажиллагааны хүрээнд Багануурын уурхай дээр 1-3 тэрбумын үйлдвэр барих хувилбарыг хэлэлцсэн боловч техник, эдийн засгийн тооцооноос харахад Багануур дээр барих үйлдвэр нь эдийн засгийн хувьд ашиггүй, Багануурын нүүрс нь чанарын хувьд хангалттай сайн биш болохыг баталсан.Иймд БНХАУ-ын талд төслийг 2014 оны 8 сард хамтран гүйцэтгэж дууссан урьдчилсан ТЭЗҮ-д үндэслэн Цайдамнуурын болон Эрдэнэцогтын уурхай дээр тус бүр жилийн 8 тэрбум шоо метрийн хүчин чадалтай Нүүрснээс байгалийн хий үйлдвэр барих нөхцлөөр үргэлжлүүлэх санал хүргүүлсэн. <br>Биелэлт-50% | 50 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | | 3. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газруудын зүгээс уг төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон татварын орчинг бүрдүүлж, бүтээгдэхүүний үнэ, борлуулалтын хугацаа, ажиллах хүч зэрэг нөхцөл, шаардлагыг Монгол Улсын эрх ашиг, олон улсын жишигт нийцүүлэх зарчмыг баримталж ажиллах. | ТБЗГ | 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдөр баталсан БНХАУ-ын Засгийн Газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийг батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 135 тоот тогтоолын хавсралтад төслийг оруулж батлуулсан. Биелэлт-90% | 90 | |
| 5 | | 4. Уг төслийн хүрээнд Улаанбаатар хотыг хийгээр бүрэн хангаж, агаарын бохирдлыг бууруулах нөхцлийг нэн тэргүүнд бүрдүүлэх эхний үйлдвэрийн техник- эдийн засгийн үндэслэлийг шуурхай боловсруулах. | ТБЗГ | Төслийн нэгж БНХАУ-ын Хийн хоолойн зураг төслийн байгууллагуудтай хамтран 2015 оны 3 дугаар сараас 7 дугаар сар хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын гэр хорооллыг нүүрсний хийгээр хангах үйлдвэрийн ТЭЗҮ болон нүүрсний хийг дамжуулах хоолойн байгууламжийн ТЭЗҮ-ийг боловсруулж, БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос 3 компанийг сонгон авч сонгон шалгаруулалт зарлахаар ажиллаж, холбогдох ажлуудыг бэлэн болгосон. Гэвч Монгол Улсын Засгийн газар 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор уг төслийн санхүүжилтийг Хөшигтийн хөндийн хурдны замын төслийг хэрэгжүүлэх нь, “Улаанбаатар Хөшигтийн хөндийн хурдны зам барих төсөл”, “Туул гол дээгүүр Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл”-д олгохоор шийдвэрлэсэн. | 50 | |
| 6 | | 5. Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх химийн үйлдвэрүүдийг байгуулах гэрээ хэлэлцээрийг хоёр талын холбогдох яамдын түвшинд байгуулах. | ТБЗГ | Төслийн хүрээнд жилд 8 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх 2 үйлдвэрийг Цайдамнуурын болон Эрдэнэцогтын ордуудыг түшиглэн байгуулах бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор Эрдэнэцогт болон Цайдам нуурын нүүрсний ордуудад жилд 80 сая тонн нүүрс олборлох нүүрсний ил уурхай байгуулагдаж, хийн үйлдвэрүүд нь 50 жилийн туршид жилд 16 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх юм. | 50 | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>Биелэлт-50%</td><td></td><td></td></tr>
<tr><td>7</td><td>2013_04/01. Байгалийн ургамал, амьтныг хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай</td><td>2. Говь, хээрийн бүсийн түлшний асуудлыг цогцоор шийдэх бодлогын хүрээнд мод, сөөг, сөөгөнцөр ургамал түлшинд хэрэглэхийг хязгаарлах зорилгоор түүхий нүүрсийг гүн боловсруулж цэвэр түлшээр төв, орон нутгийг хэрэгцээг хангах ажлыг эрчимжүүлэх;</td><td>ТБЗГ</td><td>Чиг үүргийн хувьд Аж үйлдвэрийн яаманд тус асуудал хамаарч байна.</td><td>/-/</td><td></td></tr>
<tr><td>8</td><td rowspan="4">2010_24/11. Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар</td><td>1. Монгол Улсын Засгийн газраас ордыг ашиглах үзэл баримтлалыг Улсын Их Хуралд танилцуулах баримт бичигт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн заалт чиглэлийг тодруулан тусгаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны болон шинжээчдийн санал, дүгнэлтийг тухай бүр харгалзан хэлэлцэж байх,</td><td>СБТГ</td><td rowspan="4">“Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн зарчим, удирдамж батлах тухай” УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоол, “Тавантолгойн ордыг ашиглах зарим асуудлын тухай” УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолуудыг удирдлага болгон Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын дагуу Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ашиглах Хөрөнгө оруулалтын болон бусад дагалдах гэрээний төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлэхээр Засгийн газраас өргөн барьсан.<br><br>Улсын Их Хурлын даргын 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 101 дүгээр захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Тавантолгойн ордыг хөгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ болон хавсралт гэрээнүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэгээр ахлуулан байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд: УИХ-ын гишүүн Су.Батболд, Д.Ганхуяг, А.Бакей, О.Баасанхүү, М.Сономпил, С.Ганбаатар, Д.Сумъяабазар, Б.Чойжилсүрэн, Б.Наранхүү нар орсон.<br><br>Тус Ажлын хэсэг “Тавантолгойн ордтой холбоотой гэрээ нь тухайн асуудлаар гарсан УИХ-ын болон холбогдох Байнгын хороодын тогтоолтой нийцэж байгаа эсэх”, “Гэрээ нь</td><td>90</td><td></td></tr>
<tr><td>9</td><td>2. Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичгийг монгол, англи хоёр хэлээр алдаа мадаггүй боловсруулах,</td><td>СБТГ, ТБЗГ</td><td>90</td><td></td></tr>
<tr><td>10</td><td>3. Өнгөрсөн хугацаанд болон цаашид Тавантолгойг сонирхсон гадаадын хөрөнгө оруулагчидтай хийсэн уулзалт, ярианы тэмдэглэл, саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулж, хувийн хэрэг үүсгэж, ажлын хэрэгцээнд ашиглаж байх,</td><td>СБТГ, ТБЗГ</td><td>90</td><td></td></tr>
<tr><td>11</td><td>4. Урьдчилсан сонгон шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, сонгон шалгаруулах, хэлэлцээ хийх ажлын хэсгийг тус тусад нь байгуулж ажиллуулах. Хэлэлцээ явуулахдаа мэргэжлийн</td><td>СБТГ, ТБЗГ</td><td>70</td><td></td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зохих түвшинд хадгалж, улс төрийн албан тушаалтанг хэлэлцээрийн аль нэг талд оролцуулахгүй байх зарчмыг баримтлах. | | Үндэсний Аюулгүй байдлын Үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Зөвлөмж, Засгийн газрын холбогдох шийдвэр болон төрийн эрх бүхий байгууллагын бусад шийдвэртэй нийцэж байгаа эсэх", "Гэрээ нь Монгол Улсын баримталж буй гуравдагч хөршийн бодлоготой нийцэж байгаа эсэх", "Эрдэнэс Тавантолгой" ХК-д 1072 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа иргэд болон үндэсний аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг хангаж байгаа эсэх" зэрэг нийт 14 зүйл заалт бүхий удирдамжийн хүрээнд санал, дүгнэлт гаргасан.<br>Тавантолгойн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээ, Хамтын ажиллагааны гэрээ, Концессын гэрээний төслүүдэд Уул уурхайн яамнаас Ажлын хэсэгт оролцсон төлөөлөл саналаа өгч байсан бөгөөд дээрх Ажлын хэсэгт ч холбогдох саналаа хүргүүлсэн болно.<br>Тавантолгойн ордын хөрөнгө оруулагч талууд /БНХАУ-ын Шиньхуа Энержи, Монголын Энержи Ресурс болон Японы Сумитомо корпораци/-тай байгуулах гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний явц, үр дүнг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажилласан. Мөн УИХ-ын 40 гаруй гишүүд "Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад байна. | | |
| 12 | | 5. Тавантолгойн уурхайн ашиглалт, дэд бүтэц барьж байгуулах асуудлыг "Өмнийн говь" төсөлтэй уялдуулан Улсын Их Хуралд оруулах. | СБТГ, ТБЗГ | | 70 | |